



Европын Холбоо  
санхүүжүүлэв



Food and Agriculture  
Organization of the  
United Nations

НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



UN  
DP

# БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГА БОЛОН ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ, НАСАН ТУРШИЙН  
БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, ДЭЭД БОЛОВСРОЛ



УЛААНБААТАР ХОТ  
2023 ОН

---

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

## **БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГА БОЛОН ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

### **Тайланг боловсруулсан:**

А.Заяадэлгэр, Зөвлөх

Б.Батбаяр, Зөвлөх

БШУЯ-ны санхүү, хөрөнгө оруулалтын газар

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын Ерөнхий газар

### **Хянан тохиолдуулсан:**

Б.Батцэцэг, БШУЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Энэхүү “Боловсролын салбарын 2022 оны төсвийн зарлагын болон үр дүнгийн гүйцэтгэлийн тайлан”-г Европын Холбооноос Монгол Улсын Засгийн газарт үзүүлж буй төсвийн дэмжлэгийн бүрэлдэхүүн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

**ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:** \_\_\_\_\_ ISBN 978-9919-9059-4-1

Энэхүү тайлан нь төслийн хүрээнд боловсруулагдсан бөгөөд ажлын хэрэгцээнд болон судалгаанд зориулав. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ  
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой УЯЛДСАН ТӨСВИЙН  
ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

# **БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГА БОЛОН ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ, НАСАН ТУРШИЙН  
БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, ДЭЭД БОЛОВСРОЛ

## ■ АГУУЛГА

Зургийн жагсаалт .....	5
Хүснэгтийн жагсаалт .....	6
Сайдын мэндчилгээ .....	7
Боловсролын салбарын 2022 оны үр дүнгийн гүйцэтгэлийн самбар .....	8
<b>Удиртгал .....</b>	<b>12</b>
<b>1. Сургуулийн өмнөх боловсрол .....</b>	<b>14</b>
1.1 Сургуулийн өмнөх боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм .....	14
1.2 Сургуулийн өмнөх боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт .....	16
<b>2. Ерөнхий боловсрол .....</b>	<b>21</b>
2.1 Ерөнхий боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм .....	24
2.2 Ерөнхий боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт .....	25
<b>3. Тусгай хэрэгцээт боловсрол .....</b>	<b>31</b>
3.1 Тусгай хэрэгцээт боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм .....	32
3.2 Тусгай хэрэгцээт боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт .....	33
<b>4. Насан туршийн боловсрол .....</b>	<b>34</b>
4.1 Насан туршийн боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм .....	34
4.2 Насан туршийн боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт .....	34
<b>5. Мэргэжлийн боловсрол .....</b>	<b>38</b>
5.1 Мэргэжлийн боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм .....	39
5.2 Мэргэжлийн боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт .....	40
<b>6. Дээд боловсрол .....</b>	<b>42</b>
6.1 Дээд боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм .....	45
6.2 Дээд боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт .....	46
<b>7. Боловсрол, ШУ-ны бодлого, удирдлага .....</b>	<b>47</b>
<b>8. Боловсрол, ШУ-ны судалгаа, шинжилгээ .....</b>	<b>48</b>
Нэр томъёоны товчлол .....	49
Номзүй .....	50

## ■ ЗУРГИЙН ЖАГСААЛТ

<b>Зураг 1.1</b>	Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох урсгал төсвийн зарлага, 2019 он .....	<b>15</b>
<b>Зураг 1.2</b>	Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох урсгал төсвийн зарлага, 2022 он .....	<b>15</b>
<b>Зураг 1.3</b>	СӨБ-ын үр дүнгийн үзүүлэлт, аймаг_нийслэлээр .....	<b>19</b>
<b>Зураг 1.4</b>	Сүүлийн 8 жилийн ТХЗ-ын шалгуур үзүүлэлт 4.2.2 .....	<b>19</b>
<b>Зураг 1.5</b>	ТХЗ-ын шалгуур үзүүлэлт 4.2.2, 2022-2023 хичээлийн жилийн эхэнд .....	<b>20</b>
<b>Зураг 1.6</b>	Дундаж бүлэг дүүргэлт, 2022-2023 хичээлийн жилийн эхэнд .....	<b>20</b>
<b>Зураг 2.1</b>	ЕБС-ын нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлага, 2022 он .....	<b>24</b>
<b>Зураг 2.2</b>	ЕБС-ийн нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлагын тархалт .....	<b>25</b>
<b>Зураг 2.3</b>	ЕБ-ын үр дүнгийн 2022 оны зорилтот түвшний биелэлт .....	<b>27</b>
<b>Зураг 2.4</b>	ЕБС-ын сургалтын орчны үзүүлэлтийн зорилтот түвшний биелэлт .....	<b>28</b>
<b>Зураг 2.5</b>	Бага боловсролын 2022 оны үр дүнгийн үзүүлэлт, аймаг нийслэлээр .....	<b>28</b>
<b>Зураг 2.6</b>	Дунд боловсролын 2022 оны үр дүнгийн үзүүлэлт, аймаг нийслэлээр .....	<b>29</b>
<b>Зураг 2.7</b>	БДБ-ын 2022 оны үр дүнгийн үзүүлэлт, аймаг нийслэлээр .....	<b>29</b>
<b>Зураг 2.8</b>	ТХЗ 4-ийн шалгуур үзүүлэлтийн өнөөгийн түвшин .....	<b>30</b>
<b>Зураг 3.1</b>	Нэг суралцагчид ногдох сургалтын дундаж зардал (мян.төг) .....	<b>33</b>
<b>Зураг 4.1</b>	Хүн амын сургалтад хамрагдсан байдал .....	<b>35</b>
<b>Зураг 4.2</b>	Хөдөлмөр эрхлээгүй, сургуульд сураагүй байгаа 15-24 насны залуусын хувь .....	<b>37</b>
<b>Зураг 5.1</b>	МБС-ын нэг суралцагчид ногдох төсвийн урсгал зарлага, хөдөлмөр эрхлэлтийн хамаарал .....	<b>40</b>

## ■ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	СӨБ-ын санхүүжилтийн тэгш байдлын үзүүлэлт .....	16
Хүснэгт 1.2	СӨБ хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүний өртөг .....	16
Хүснэгт 1.3	СӨБ-ын үр дүнгийн 2022 оны зорилтот түвшний биелэлт .....	18
Хүснэгт 2.1	Санхүүжилтийн тэгш байдлын үзүүлэлт .....	25
Хүснэгт 2.2	ЕБ хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүний өртөг .....	26
Хүснэгт 3.1	Тусгай боловсролын сургуулийн урсгал төсвийн зарлагын гүйцэтгэл .....	32
Хүснэгт 3.2	Хамран сургалтын тооцсон хувь .....	33
Хүснэгт 4.1	НТБ хөтөлбөрийн хүрээнд 2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүний өртөг .....	35
Хүснэгт 4.2	НТБ хөтөлбөрийн үр дүнгийн зорилтот түвшний биелэлт .....	36
Хүснэгт 5.1	МБ хөтөлбөрийн хүрээнд 2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүний өртөг .....	40
Хүснэгт 5.2	НТБ-ын 2022 оны үр дүнгийн зорилтот түвшний биелэлт .....	41
Хүснэгт 6.1	Дээд боловсролын төсвийн зарлага, бүтээгдэхүүний өртөг .....	45
Хүснэгт 6.2	Дээд боловсролын 2022 оны үр дүнгийн зорилтот түвшний биелэлт .....	46
Хүснэгт 7.1	Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага, 2022 оны төсвийн урсгал зарлага .....	47
Хүснэгт 8.1	Боловсрол, ШУ-ны судалгаа, шинжилгээ, 2022 оны төсвийн урсгал зарлага .....	48

## МЭНДЧИЛГЭЭ



Та бүхэнд Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яамны өмнөөс болон хувиасаа ажлын амжилт хүсэж, энэ өдрийн амар амгаланг эрвэ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаас 2015 онд “Дэлхийн тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийг батлан, ирэх 15 жилийн хөгжлийн гарцыг “Хөгжлөөс хэнийг ч үлдээж, хоцроохгүй байх” уриалга, амлалтын дор дэлхий нийтээрээ нэгдсэн. Дэлхийн тогтвортой хөгжил 2030-ын “Чанартай боловсролыг дэмжих” 4 дүгээр зорилгод хүрэхийн төлөө НҮБ-ын салбар байгууллагуудтай БШУЯ хамтран ажилладаг.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран үр дүнд чиглэсэн төсвийн удирдлагыг хөгжүүлэх, бодлогын хэрэгжилттэй төсвийг уялдуулах, гүйцэтгэлийн төлөө хариуцлага хүлээдэг болох, боловсролын үр дүнг хүн ам, суралцагчид, өрх гэр, аж ахуйн нэгжүүд зэрэг эцсийн хэрэглэгчдэд бодитой хүргэхийн төлөө ажиллаж байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулинд зааснаар төсвийн ерөнхийлөн захирагчид нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлж, боловсролын салбарын 2022 оны төсвийн зарлага болон үр дүнгийн зорилтот түвшний гүйцэтгэлийг гаргаж иргэд Та бүхэнд тайлагнаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.” гэж заасан. Хуульд заасан боловсролын үйлчилгээг иргэдэд хүргэх, Засгийн газрын дэвшүүлсэн бодлогыг хэрэгжүүлэхээр 2022 онд боловсролын салбарт нийт 2,418 байгууллага, 89,966 ажилтан, албан хаагч ажиллалаа.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад 2,245,749.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, үүнээс 2,223,678.4 сая төгрөг зарцуулж гүйцэтгэл 99.5 хувь, нийт зарлага ДНБ-ний 4.13 хувийг эзэлж байна.

Тус хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ) нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд сургуулийн өмнөх боловсролын 2, ерөнхий боловсролын 17, насан туршийн боловсролын 2, дээд боловсролын 4, мэргэжлийн боловсролын 3 үзүүлэлт батлагдсан бөгөөд эдгээрийн 2022 оны зорилтот түвшний биелэлтийг гаргав. Боловсролын үр дүнгийн нийт 27 үзүүлэлтийн 2022 оны зорилтот түвшний ерөнхий биелэлт 99.5 хувь байна.

Боловсролын салбарыг хөгжүүлэх, ирээдүй хойч үе, нийт хүн амд боловсрол, ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх их үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж буй салбарын нийт багш, ажилтан, албан хаагчдад талархал илэрхийлье.

## БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2022 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН САМБАР



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ

2,223,687,422

БШУ-ны ТЭЗ-ын 2022 оны нийт зарлага /мян.төг/


4.13%

ДНБ-д эзлэх хувь


71800	Хөтөлбөрүүд	2022 оны нийт зарлага /мян.төг/	ДНБ-д эзлэх хувь
71801	Сургуулийн өмнөх боловсрол	617,156,484.1	1.15%
71802	Ерөнхий боловсрол	1,333,238,510.3	2.48%
71803	Дээд боловсрол	60,485,505.7	0.11%
71804	Мэргэжлийн боловсрол	80,881,554.6	0.15%
71805	Шинжлэх ухаан, технологи	67,259,660.0	0.12%
71806	Насан туршийн боловсрол	5,427,801.6	0.01%
71807	Тусгай хэрэгцээт боловсрол	12,648,546.3	0.02%
71808	Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	34,992,752.3	0.06%
71809	Боловсрол, ШУ-ны судалгаа шинжилгээ	11,596,607.4	0.02%

2022 онд боловсролын салбарт ДНБ-ний 4%-ийг зарцуулжээ. Энэ нь улсын нийт төсвийн 19% болж байна.

Сүүлийн 10 жилд Боловсролын салбарын зарлагын ДНБ-д эзлэх дундаж хувь 4.7%




Боловсролын төсвийн зарлагын улсын төсвийн нийт зарлагад эзлэх дундаж хувь 15.5%





## Боловсролын үр дүнгийн 2022 оны зорилтот түвшний ерөнхий биелэлт

99.5%




## Ерөнхий боловсрол

2022-2023 оны хичээлийн жилийн үзүүлэлт

Төрийн өмчийн сургуулийн тоо	Төрийн өмчийн сургуулийн суралцагчдын тоо	Төрийн өмчийн сургуулийн дундаж бүлэг дүүргэлт	Төрийн өмчийн сургуулийн бага ангийн нэг багшид ногдох суралцагчдын тоо	Төрийн өмчийн сургуулийн дунд ангийн нэг багшид ногдох суралцагчдын тоо
688	683,708	31	33	16
Төрийн бус өмчийн сургуулийн тоо	Төрийн бус өмчийн сургуулийн суралцагчдын тоо	Төрийн бус өмчийн сургуулийн дундаж бүлэг дүүргэлт	Төрийн бус өмчийн сургуулийн бага ангийн нэг багшид ногдох суралцагчдын тоо	Төрийн бус өмчийн сургуулийн дунд ангийн нэг багшид ногдох суралцагчдын тоо
171	62,697	22	25	10

## Суралцагчдын тоо




● Төрийн өмчийн ● Хувийн өмчийн

## Сургуулийн өмнөх боловсрол

2022-2023 оны хичээлийн жилийн үзүүлэлт

Төрийн өмчийн цэцэрлэгийн тоо	Төрийн бус өмчийн цэцэрлэгийн тоо	Үндсэн бүлэгт суралцсан хүүхдийн тоо	Хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	Төрийн бус өмчийн цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо
985	428	216,016	15,567	34,441
Цэцэрлэгийн насны хүн амын тоо /3-5 настай/	Цэцэрлэгийн насны хүн амын тоо /2-5 настай/	Үндсэн багшийн тоо	Төрийн өмчийн цэцэрлэгийн бүлэг дүүргэлт	
228,302	304,436	9450	28	

Төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо




## Мэргэжлийн боловсрол

2022-2023 оны хичээлийн жилийн үзүүлэлт

Техникийн болон мэргэжлийн боловсролын төрийн өмчийн сургуулийн тоо	Техникийн болон мэргэжлийн боловсролын төрийн бус өмчийн сургуулийн тоо	Төрийн өмчийн техникийн болон мэргэжлийн боловсролын сургуулийн суралцагчдын тоо	Төрийн бус өмчийн техникийн болон мэргэжлийн боловсролын сургуулийн суралцагчдын тоо
48	30	27,400	10,634
Шинээр элсэгчид	9-р анги төгсөөд шүүд элсэн хувь	Үндсэн багш	Багш болон багш бус ажиллагсдын тооны харьцаа
19,256	40.6%	2,252	1.2
			МБС-ийн насны хүн амын тоо /15-24 настай/
			449,706

Нийт суралцагчид



## Насан туршийн боловсрол

2022-2023 оны хичээлийн жилийн үзүүлэлт

Насан туршийн суралцахуйн төвийн тоо	Нийт ажиллагсдын тоо	Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдын тоо	Орой, эчнээгээр суралцагчдын тоо
30	623	4,981	127
НТСТ-ийн зохион байгуулсан зүүчилсэн, хамтарсан 8 төрлийн сургалтад хамрагдсан хүний тоо		Насанд хүрсэн хүн амын сургалтын хамран сургалт /18-аас дээш насны хүн ам/	
231,154		11%	


## Дээд боловсрол

2022-2023 оны хичээлийн жилийн үзүүлэлт


Нийтийн өмчийн их, дээд сургуулийн тоо	Хувийн өмчийн их, дээд сургуулийн тоо	Нийтийн өмчийн их, дээд сургуулийн суралцагчид	Хувийн өмчийн их, дээд сургуулийн суралцагчид	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч
16	53	79,718	58,828	414
Тухайн хичээлийн жилийн шинээр элсэгчид	Шинээр элсэгчдээс тухайн жилд 12 дугаар анги төгссөн	Их, дээд сургуулийн багшийн тоо	Багш болон багш бус ажиллагсдын тооны харьцаа	
26,316	19,835	5,169	1	

Тухайн хичээлийн жилд 12 дугаар анги төгссөн элсэгчдийн хувь

Тухайн хичээлийн жилд 12 дугаар анги төгссөн элсэгчдийн хувь



Нийт суралцагчид



## УДИРТГАЛ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14.3, 41.2.3, 41.2.7, 41.7 болон 54.5-д заасныг баримтлан Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн зарлага болон үр дүнгийн гүйцэтгэлийн тайланг Та бүхэнд толилуулж байна.

Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагч нь дараах төсвийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.<sup>1</sup>

71800	Боловсрол, шинжлэх ухаан	Төрөл
71801	Сургуулийн өмнөх боловсрол	Төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн санхүүжилтийн хөтөлбөр
71802	Ерөнхий боловсрол	Төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн санхүүжилтийн хөтөлбөр
71803	Дээд боловсрол	Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр
71804	Мэргэжлийн боловсрол	Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр
71805	Шинжлэх ухаан, технологи	Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр
71806	Насан туршийн боловсрол	Төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн санхүүжилтийн хөтөлбөр
71807	Тусгай хэрэгцээт боловсрол	Төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн санхүүжилтийн хөтөлбөр/БСШУЯ-ны шууд хэрэгжүүлдэг хөтөлбөр
71808	Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	БШУ-ны Сайдын шууд хэрэгжүүлдэг хөтөлбөр
71809	Боловсрол, ШУ-ны судалгаа шинжилгээ	БСШУЯ-ны шууд хэрэгжүүлдэг хөтөлбөр

Энэ тайланд сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, насан туршийн боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол, мөн Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага, Боловсрол, ШУ-ны судалгаа шинжилгээ хөтөлбөрийн төсвийн зарлага, үр дүнг тайлагнах юм. Шинжлэх ухаан, технологи хөтөлбөрийн төсвийн зарлага болон үр дүнгийн гүйцэтгэл энэ тайланд багтаагүй болно.

Боловсролын салбарын төсвийн зарлага, үр дүнгийн гүйцэтгэлийн жилийн тайланг боловсруулахдаа төсвийн зарлагыг 2022 оны төсвийн жилээр<sup>2</sup>, суралцагчдын тоог 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилийн санхүүжсэн дундаж тоогоор, үр дүнгийн зарим үзүүлэлтийг 2021-2022 оны хичээлийн жилээр, сургалтын орчны үзүүлэлтийг 2022-2023 оны хичээлийн жилийн эхний мэдээгээр, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүн амын үзүүлэлтийг 2022 оны жилийн эцсийн хүн амын мэдээгээр гаргав.

<sup>1</sup>Сангийн сайдын 2015 оны 7-р тушаалаар баталсан хөтөлбөрүүд.

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 4.1.16."хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээ; Төсвийн тухай хуулийн 4.1.17."арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг; Төсвийн тухай хуулийн 1.23."төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийн санхүүжилт" гэж энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг санхүүжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон зориулалт, нөхцөл, шаардлагын дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллагад холбогдох шатны төсвөөс олгох хөрөнгийг хэлнэ.

<sup>2</sup>Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 7.1.Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.



2022 оны төсвийн жил: 2021-2022 оны хичээлийн жил /10\*6+2022-2023 оны хичээлийн жил/10\*4

---

## 1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 71801 Сургуулийн өмнөх боловсрол төсвийн хөтөлбөр нь Боловсролын тухай хууль<sup>3</sup> болон СӨБ-ын тухай хуулинд<sup>4</sup> заасан үйлчилгээг иргэдэд хүргэх зориулалттай.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын Хоёр. Хүний хөгжил хэсэгт дэвшүүлсэн зорилгод хүрэх, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.1.1, 2.1.3, 2.1.7, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.1, 2.3.2, 2.3.4, 2.3.9, 2.3.11-д заасан арга хэмжээг мөн хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Засгийн газрын урт болон дунд хугацааны бодлогын зорилгод хүрч, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө 2022 онд “Бага насны хүүхдийн цогц хөгжил”-ийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэ бодлогын хүрээнд (i) бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх, (ii) гэр бүл, олон нийтэд суурилсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх, (iii) бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, (iv) бага насны хүүхдийн хөгжлийг хянах мэдээлэл, хяналтын тогтолцоо бүрдүүлэхээр ажиллаж байна.<sup>5</sup>

### 1.1 Сургуулийн өмнөх боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг тухайн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ болон байгууллага нэг бүрээр гаргалаа. Төсвийн зарлагын гүйцэтгэлийн дэлгэрэнгүй тайланг Сангийн яамны сайтаас харах боломжтой.<sup>6</sup>

Сургуулийн өмнөх боловсролын урсгал зардалд 2022 онд нийт 563,992 сая төгрөг төлөвлөснөөс 548,076.3 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 97.2 хувь байна. Мөн хөрөнгө оруулалтад 69,080.2 сая төгрөг зарцуулаа. Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн нийт өртөг 617,156.5 сая төгрөг болж ДНБ-ний 1.15 хувийг эзэлж байна.<sup>7</sup>

Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох урсгал төсвийн зарлага 2019 онд дунджаар 1,519.3 мянган төгрөг байсан<sup>8</sup> бол 2022 онд 2,636.5 мянган төгрөг болж өслөө.

---

<sup>3</sup> Хуучин хуулиар

<sup>4</sup> Хуучин хуулиар


<sup>5</sup> БШУЯ (2023) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр: Боловсрол, шинжлэх ухааны яамны 2022 оны жилийн эцсийн тайлан.

<sup>6</sup> [https://mof.gov.mn/data\\_grid/total-budget](https://mof.gov.mn/data_grid/total-budget)


<sup>7</sup> ҮСХ 1212 мн: Тухайн оны үнээр, 2022 онд ДНБ 53,851,544.5 сая. төгрөг

<sup>8</sup> НҮБХХ (2020)

Зураг 1.1 Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох урсгал төсвийн зарлага, 2019 он



Зураг 1.2 Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох урсгал төсвийн зарлага, 2022 он



Аймаг болон нийслэлээр тооцсон нэг хүүхдэд ногдох урсгал төсвийн дундаж зарлагын вариацийн коэффициент 2019 онд 12.6 хувь байсан бол<sup>9</sup> боловсролын санхүүжилтийн тогтолцоонд шинэчлэлт хийсний үр дүнд 2022 оны гүйцэтгэлээр 9.7 хувь болж буурсан, нэг хүүхдэд ногдох урсгал төсвийн зарлагын медиан хэмжээгээр тооцсон МакЛун индекс<sup>10</sup> 92% болж өссөн байна.

<sup>9</sup> НҮБХХ (2020)

<sup>10</sup> МакЛун индекс (McLoone Index) нэг суралцагчид ногдох зарцуулалтын тархалтыг харуулах бөгөөд 100% бол санхүүжилтийн төгс тэгш байдалд хүрнэ гэж үзнэ.

Хүснэгт 1.1 СӨБ-ын санхүүжилтийн тэгш байдлын үзүүлэлт

Үзүүлэлт	2019 оны гүйцэтгэлээр	2022 гүйцэтгэлээр
Голч	1,519,291	2,636,500
Стандарт хазайлт	191,930	255,600
Вариацийн коэффициент	12.6%	9.7%
Медиан	1,492,930	2,623,000
МакЛун индекс	90.3%	92%

## 1.2 Сургуулийн өмнөх боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 5 настай бүх хүүхдийг хамруулахын зэрэгцээ малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө эрчимтэй арга хэмжээ авч ажиллаж байна.<sup>11</sup> Нийслэлийн хувьд цэцэрлэгийн “сугалаатай” бүртгэлийг халж, Е-Монголиа цахим системээр цэцэрлэгийн хүүхдийг бүртгэж, оршин суугаа хаягийн ойролцоо цэцэрлэгт элсэн суралцах боломжтой боллоо. Үр дүнд нь цэцэрлэгт хамрагдахыг хүссэн хүүхэд бүр аюулгүй ээлтэй хамгаалагдсан орчинд суралцах, эцэг эх, асран хамгаалагчид ажил хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлөөр хангагдах юм.

Хөтөлбөрийн төлөвлөсөн үр дүнд хүрэхийн төлөө хэрэгжүүлсэн арга хэмжээ нэг бүрийн төсвийн зарлагын гүйцэтгэл, нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ, нэгжийн өртгийг тооцов.

2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн 972 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж үндсэн бүлэгт 178,444, хувилбарт сургалтад 12,547 хүүхэд хамрагдсан бол 2022-2023 оны хичээлийн жилд 985 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж үндсэн бүлэгт 250,457, хувилбарт сургалтад 15,567 хүүхэд хамрагдлаа.

2021-2023 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн 481 цэцэрлэгт 31,155 хүүхэд, 2022-2023 оны хичээлийн жилд 428 цэцэрлэгт 34,441 хүүхэд хамрагдав.

Хүснэгт 1.2 СӨБ хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүний өртөг

Код	Арга хэмжээ	Бүтээгдэхүүнийг хэмжих үзүүлэлт	2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/	Нэгжийн өртөг /мян.төг/
<b>Төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн санхүүжилтийн арга хэмжээ</b>					
81834	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	Санхүүжих дундаж хүүхдийн тоо	171,288	224,827,300	1,313
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	Төрийн өмчийн цэцэрлэгийн тоо	985	157,112,080	159,505
81605	Эрүүл мэндийг дэмжих	Үйлчилгээнд хамрагдсан багшийн тоо	15,144	13,659,576	902
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	Санхүүжих дундаж хүүхдийн тоо	171,288	68,528,746	400

<sup>11</sup> OECD (2022) Education at Glance. <https://www.oecd-ilibrary.org/docserver/3197152b-en.pdf?expires=1691750683&id=id&accname=guest&checksum=B3C939C036C178368D6877B7E2EC6721>



Код	Арга хэмжээ	Бүтээгдэхүүнийг хэмжих үзүүлэлт	2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/	Нэгжийн өртөг /мян.төг/
<b>Төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн санхүүжилтийн арга хэмжээ</b>					
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	Санхүүжих дундаж хүүхдийн тоо	171,288	25,108,015	147
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	Мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо	554	1,652,393	2,983
80508	Төрийн бус өмчийн байгууллагад төсвөөс олгох дэмжлэг	Санхүүжих дундаж хүүхдийн тоо	33636	33,872,180	1,007
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	Тэтгэмж авсан хүний тоо	3,201	18,090,222	5,651.4
<b>Дүн</b>				<b>542,850,513.1</b>	

#### Боловсрол, шинжлэх ухааны сайдын шууд хэрэгжүүлдэг арга хэмжээ

Код	Арга хэмжээ	Бүтээгдэхүүнийг хэмжих үзүүлэлт	2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/	Нэгжийн өртөг /мян.төг/
81821	Төмөр замын цэцэрлэгийн үйлчилгээ	Санхүүжих дундаж хүүхдийн тоо	3,491	3,805,414	1,090
81845	Хүүхэд хөгжил хөтөлбөр	СӨБ-ын нийт хүүхдийн тоо	190,991	1,420,364	
<b>Дүн</b>				<b>5,225,778</b>	

#### Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Код	Арга хэмжээ	2022 оны зарлага /мян.төг/
1	Хөрөнгө оруулалтын зарлага	<b>69,080,193.1</b>

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ) нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд сургуулийн өмнөх боловсролын үр дүнгийн хоёр (2) үзүүлэлт батлагдсан<sup>12</sup> бөгөөд эдгээр үзүүлэлтийн гүйцэтгэлийг салбарын захиргааны статистикийн маягтаар гардаг хичээлийн жилийн тайланд үндэслэн тооцов.<sup>13</sup>

Сургуулийн өмнөх боловсролын 2022 оны үр дүнгийн үзүүлэлтийн зорилтот түвшний ерөнхий биелэлт 113.7 хувь гарлаа.

<sup>12</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381595772311>

<sup>13</sup> Өгөгдлийг БШУЯ-ны esis.eu.mn-ээс авав.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 2-5 настай хүн амаар тооцвол 92 хувь, харин 3-5 настай хүн ам болон цэцэрлэг, хувилбарт сургалтад хамрагдсан 3-5 настай хүүхдийн тоогоор тооцвол 95.8 хувь байна. 2022-2023 хичээлийн жилийн эхэнд 1-р ангид элсэгчдийн 86.7 хувь нь сургуульд элсэхийн өмнөх 1 жилд сургуулийн өмнөх боловсрол олгох зохион байгуулалттай сургалтад хамрагдсан байна.

*Хүснэгт 1.3 СӨБ-ын үр дүнгийн 2022 оны зорилтот түвшний биелэлт*

Хэмжих үзүүлэлт	Хэмжих цаг хугацаа	2022 оны зорилтот түвшин	2022 оны гүйцэтгэл	Биелэлт
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь, үндсэн сургалтаар /2-5 нас/	2022-2023 оны хичээлийн жил	74%	82%	<b>118.1%</b>
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь, хувилбарт сургалтаар /2-5 нас/	2022-2023 оны хичээлийн жил		5.11%	
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь, үндсэн сургалтаар /3-5 нас/	2022-2023 оны хичээлийн жил	74%	85.2%	<b>122.3%</b>
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь, хувилбарт сургалтаар /3-5 нас/	2022-2023 оны хичээлийн жил		5.3%	
Сургуульд элсэхийн өмнөх 1 жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдсан хувь	2022-2023 оны хичээлийн жил	86	86.7%	<b>100.8%</b>

Сургуулийн өмнөх боловсролын 2022 оны үр дүнгийн хоёр үзүүлэлтийг аймаг, нийслэлээр гаргав. Хамран сургалтын хувийг гаргахдаа тухайн орон нутагт бүртгэлтэй хүн амаар тооцлоо. Төмөр замын цэцэрлэгүүдэд 2022-2023 оны хичээлийн жилд 3,266 хүүхэд хамрагдсан бөгөөд үүнийг нийслэлийн хамран сургалтад оруулав. Дараах зурагт сургуульд элсэхийн өмнөх 1 жилд СӨБ-д хамрагдсан хувиар эрэмбэллээ.


Сураг 1.3 СӨБ-ын үр дүнгийн үзүүлэлт, аймаг\_нийслэлээр

Аймаг_Нийслэл	СӨБ-ын хамран сургалт, 3-5 нас	1-р ангид элсэгчдийн СӨБ-д хамрагдсан хувь	Хамран сургалтын улсын дундажтай харьцуулсан хэлбэлзэл	1-р ангид элсэгчдийн СӨБ-д хамрагдсан хувийн улсын дундажтай харьцуулсан хэлбэлзэл
Сүхбаатар	94.9%	96.4%	4.4%	9.7%
Говь-Алтай	93.5%	96.3%	3.0%	9.6%
Дорноговь	82.6%	94.3%	-7.9%	7.7%
Орхон	96.0%	93.5%	5.5%	6.8%
Говьсүмбэр	90.6%	93.0%	0.1%	6.3%
Дундговь	85.7%	92.4%	-4.8%	5.7%
Сэлэнгэ	85.7%	90.2%	-4.8%	3.5%
Дархан-Уул	90.2%	90.1%	-0.3%	3.5%
Хэнтий	91.5%	89.9%	1.0%	3.3%
Баянхонгор	92.5%	88.9%	2.0%	2.2%
Улаанбаатар	91.5%	87.7%	1.0%	1.0%
Өмнөговь	89.9%	87.7%	-0.6%	1.0%
Завхан	88.1%	87.3%	-2.4%	0.6%
Дорнод	90.0%	86.9%	-0.5%	0.2%
Увс	94.2%	84.7%	3.7%	-2.0%
Төв	94.6%	84.5%	4.1%	-2.2%
Ховд	88.7%	83.7%	-1.8%	-3.0%
Булган	84.3%	81.7%	-6.2%	-4.9%
Архангай	93.8%	81.4%	3.3%	-5.3%
Өвөрхангай	91.2%	81.0%	0.7%	-5.6%
Хөвсгөл	86.9%	80.4%	-3.6%	-6.3%
Баян-Өлгий	78.7%	65.1%	-11.8%	-21.6%




Тогтвортой хөгжлийн зорилго 4.Чанартай боловсролыг дэмжих зорилгын хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтийн 4.2.2 Сургуульд элсэн орохын өмнөх 1 жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдсан хувийг тогтмол гаргаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд хамран сургалтыг нэмэгдүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн нь 2023-2024 оны хичээлийн жилд харагдах болно.

Сураг 1.4 Сүүлийн 8 жилийн ТХЗ-ын шалгуур үзүүлэлт 4.2.2




2022-2023 оны хичээлийн жилд 1-р ангид элссэн суралцагчдын сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хувь Баян-Өлгий аймагт хамгийн доогуур буюу 65.1 хувь байсан бол Говь-Алтай аймагт хамгийн өндөр 96.3 хувь байв.

Зураг 1.5 ТХЗ-ын шалгуур үзүүлэлт 4.2.2, 2022-2023 хичээлийн жилийн эхэнд



Баян-өлгий аймагт төрийн өмчийн цэцэрлэгүүдийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлтийн дундаж 26 байна. Иймд тус аймагт 3-5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт доогуур байгаа нь хүчин чадлын асуудал биш юм.

Зураг 1.6 Дундаж бүлэг дүүргэлт, 2022-2023 хичээлийн жилийн эхэнд



---

## 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ

Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 71802 Ерөнхий боловсрол хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 7/сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно...; мөн Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хуульд<sup>14</sup> заасан үйлчилгээг иргэдэд хүргэх зориулалттай.

Дунд хугацаанд “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын Хоёр. Хүний хөгжил хэсэгт дэвшүүлсэн зорилтод хүрэх, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.1.2, 2.1.3, 2.1.6, 2.17, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.4, 2.3.9, 2.3.10-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Засгийн газрын урт болон дунд хугацааны бодлогын зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө ерөнхий боловсролын салбарт 2022 онд хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дараах ажлуудыг онцолж байна.<sup>15</sup>

Суралцагчдын хичээлийн хоцрогдлыг нөхөх, боловсролыг тэгш хүртээмжтэй болгох, суралцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор боловсролын цахим сургалтын платформыг (medle.mn) хөгжүүлж байна. 2022 онд цахим санд 2,590 контент нэмж байршуулан 5,196 контентыг байршуулахаар хянаж байна.<sup>16</sup> Тус платформд 147 цахим сурах бичиг, 4140 теле хичээл, 6-12 дугаар ангийн математик, физик, хими, биологийн хичээлд ашиглах 805 виртуаль лаборатори, эрүүл мэнд, замын хөдөлгөөний чиглэлээр 152 контент, суралцагчдад зориулсан 85 (Microsoft 365) цахим хичээл, контент боловсруулах арга зүйн зөвлөмж, насан туршийн боловсрол, цахим ур чадварын 413 контент, хоцрогдол нөхөх арга зүйн зөвлөмжийг бүх ангийн бүх хичээлээр байршуулан багш нар хичээл сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Энэхүү цахим сургалтын платформыг төрийн болон хувийн хэвшлийн сургуулиуд харгалзахгүйгээр улсын хэмжээнд бүрэн ашиглаж байгаагаараа онцлогтой юм. Мөн 2022-2023 оны хичээлийн жилд 10 дугаар ангийн 16 сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулж нийт 14,552 суралцагчийг 620 бүлэгт хуваарилан 148 багш цахим хичээл, сургалтын үйл ажиллагаа явуулав.<sup>17</sup>

---

<sup>14</sup> Хуучин хуулиар

<sup>15</sup> БШУЯ (2023) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр: Боловсрол, шинжлэх ухааны яамны 2022 оны жилийн эцсийн тайлан.

<sup>16</sup> БШУ-ны Сайдын 2022 оны “Журам батлах тухай” 123 дугаар тушаалаар баталсан ЕБС-ийн контентын санг бүрдүүлэх журам болон БШУ-ны Сайдын 2022 оны “Аргачлал шинэчлэн батлах тухай” А/384 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын хичээлийн контент сонгон шалгаруулах аргачлал”-ын дагуу багш нарын дунд контентын нээлттэй сонгон шалгаруулалт тогтмол явуулж 2022 оны жилийн эцсийн байдлаар 6,248 багш холбогдож, 6,029 контент боловсруулах санал ирүүллээ.

<sup>17</sup> БШУ-ны Сайдын “Цахим сургалт зохион байгуулах, зардал батлах тухай” 2022 оны 143 дугаар тушаал

---

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтыг үнэлэх “PISA-2022” Олон улсын үндсэн судалгааг 2022 оны 4-5 дугаар сард зохион байгууллаа. Судалгаанд нийслэлийн 85, хөдөө орон нутгийн 110 нийт 195 сургуулийн 7,300 орчим сурагчийг түүврээр хамруулсан бөгөөд тэдний математик, байгалийн ухаан, уншиж ойлгох чадвар болон бүтээлч сэтгэлгээний мэдлэг, чадварыг үнэлэх шалгалт, судалгааг компьютерт суурилсан хэлбэрээр зохион байгуулав. Өгөгдөл болон өгөгдлийн талаарх тайланг ЭЗХАНБ (OECD)-д хүргүүлсэн бөгөөд эцсийн үр дүн нь 2023 оны 12 дугаар сард гарахаар хүлээгдэж байна.<sup>18</sup>

Боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулахад шаардлагатай судалгааны ажлын жагсаалтыг гаргаж, түүний дагуу “Гадаад улс орны сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээ, суралцагчийн эзэмших ур чадварын харьцуулсан судалгаа”, “Нийгмийн эрэлт хэрэгцээ болон ирээдүйн суралцагчийн заавал эзэмших шаардлагатай мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлийн судалгаа”, “Бага, суурь, бүрэн дунд боловсролын одоо хүчин төгөлдөр мөрдөж буй сургалтын хөтөлбөрт тусгасан чадварын судалгаа”-г тус тус хийж, олон удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, түүнээс гарсан зарим санал, зөвлөмжийг сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгалаа.<sup>19</sup>

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж буй сургуулийн тоог үе шаттай нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр баг байгуулав.<sup>20</sup> Багийн судалгааны ажлын дүнд ерөнхий боловсролын сургуулиудад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын замын зураглал хийж, Кембрижийн их сургуультай хамтран ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуульд мөрдөгдөж байгаа хөтөлбөрийн дагуу 2022-2023 оны хичээлийн жилд I-V ангийн суралцагчдад 1,2 сая ширхэг, VI-XII ангийн суралцагчдад түрээсээр ашиглуулах 1,0 сая ширхэг сурах бичгийг хэвлүүлэн хэвлэлийн компаниудтай хийсэн гэрээний дагуу суралцагчдад бүрэн хүргэв. Мөн БШУ-ны сайдын тушаалаар<sup>21</sup> “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлага”-ыг батлан хэрэгжүүлж байна.

“Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандарт”-ыг боловсруулж, Стандарт хэмжил зүйн газарт батлуулахаар хүргүүлэв. ЕБС-д шаардлагатай хоолны газрын тоног төхөөрөмжийн хэрэгцээ, техникийн тодорхойлолт, үнийн судалгааг боловсруулж, улсын төсвөөр 1.0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж байна. Улсын хэмжээнд 2022 онд 134 сургуулийг нийт 888 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмжөөр ханган, мөн шинээр ашиглалтад орсон 15 цэцэрлэг, 11 сургуулийн өргөтгөлд тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, сургалтын бусад хэрэглэгдэхүүн нийлүүлэв. Ингэснээр нийт сургуулийн 46.8 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангаад байна.

---

<sup>18</sup> <https://www.oecd.org/pisa/aboutpisa/pisa-2022-participants.htm>

<sup>19</sup> “Гадаад улс орнуудын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын бүтэц, агуулгыг харьцуулан судалсан судалгааны ажлын үр дүн”-г хэлэлцүүлэх 8 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав.

<sup>20</sup> БШУ-ны Сайдын 2022 оны “Багийн бүрэлдэхүүн, зардал батлах тухай” А/167 дугаар тушаал

<sup>21</sup> БШУ-ны Сайдын 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/375 дугаар тушаал

---

Засгийн газрын 2021 оны “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын үдийн хоолны зардлыг шинэчлэн тогтоож, 2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бага ангийн сурагчид үдийн цайны үйлчилгээнээс үдийн хоолны үйлчилгээнд шилжээд байна. 2022-2023 оны хичээлийн жилд бага ангийн 371,480 сурагч үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд нийт сургуулийн 99 хувь нь үдийн хоолоор үйлчилж байна.<sup>22</sup> Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар дунд ангийн сурагчдын үдийн хоолны үйлчилгээнд шилжих хугацааг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин бүрдэх хүртэл үе шаттайгаар эхлүүлэхээр шийдвэрлэсэн.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хамран сурах тойрог, кластер системийг шийдвэр гаргах түвшинд оновчтой болгох зорилгоор Газар зүйн мэдээллийн системд (ГЗМС)<sup>23</sup> тулгуурласан бодлого, төлөвлөлтийн системийг 2022 оны 3 дугаар сараас нэвтрүүлэн ажиллаж байна. Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд хүргүүлж буй салбарын хөрөнгө оруулалтын шинэ төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг энэхүү газар зүйн мэдээллийн системд тулгуурласан шинжилгээгээр боловсруулж, 2023 оны улсын төсвийн төсөлд нийт 477 шинэ төсөл, арга хэмжээний санал ирүүлснээс ГЗМС-ийн шинжилгээгээр 88 төсөл, арга хэмжээг нэн шаардлага, хэрэгцээтэй гэж үзэн Сангийн яам болон Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. ГЗМС-ийн шинжилгээг барилгын насжилт, хүчин чадал, хамран сургах тойргийн суралцагч, одоогийн суралцагчийн тоо, тухайн бүс нутгийн хүн амын өсөлт, суралцагчийн амьдран суугаа хаяг, байршил, суралцаж буй сургуулийн хаяг, байршил зэрэг үзүүлэлтийг тооцон хийж байна.<sup>24</sup>

Цахим сургалтын орчинг бүрдүүлэх ажлыг үе шаттай хийж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцаас нийслэл, орон нутгийн 18 ерөнхий боловсролын сургуульд Мэдээлэл зүйн танхимын тоног төхөөрөмж нийлүүлэв. Төрийн өмчийн бүх сургуулиудад компьютер тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 33,300.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг сургуулийн захирлуудад шилжүүлэв.<sup>25</sup>

Мөн БШУ-ны сайдтай байгуулсан гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багш нарыг компьютерээр хангах ажлыг хэд хэдэн аймаг санаачлан зохион байгуулжээ. Үүнд салбарын хамт олны өмнөөс талархал илэрхийлж байна.

---

<sup>22</sup> Нийслэлд 8, Хөвсгөл, Өвөрхангай аймагт 4 сургууль бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилж байна

<sup>23</sup> A Geographic Information System (GIS) is a computer system that analyzes and displays geographically referenced information. It uses data that is attached to a unique location. <https://www.usgs.gov/faqs/what-geographic-information-system-gis>

<sup>24</sup> Барилга, хот байгуулалтын яамнаас зарласан нэг маягийн зураг, төсөл боловсруулах тендерт шалгарсан байгууллагуудаас ирүүлсэн “200 Ортой дотуур байрны барилгын нэг маягийн зураг төсөл” /6,7,8,9 балл/, “480 суудалтай сургуулийн барилгын нэг маягийн зураг төсөл” /6,7,8,9 балл/, “240 Ортой цэцэрлэгийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл” /6,7,8,9 балл/, “280 Ортой цэцэрлэгийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл” /6,7,8,9 балл/-ийн ажлын загвар зурагт боловсролын байгууллагын норм, стандартын дагуу өөрчлөлт хийх саналыг хүргүүлэв.

<sup>25</sup> БШУ-ны Сайдын 2022 оны 11 дүгээр 8-ны өдрийн А/452 дугаар тушаал




## 2.1 Ерөнхий боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм

Ерөнхий боловсролын урсгал зардалд 2022 онд нийт 1,152,259 сая төгрөг төлөвлөснөөс 1,140,137.0 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 98.9 хувь байна. Мөн хөрөнгө оруулалтад 193,101.5 сая төгрөг зарцууллаа. Ерөнхий боловсрол хөтөлбөрийн нийт өртөг 1,333,238.5 сая төгрөг болж энэ нь ДНБ-ний 2.48 хувийг эзэлж байна.<sup>26</sup>

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлага 2019 онд дунджаар 1,488.6 мянган төгрөг байсан бол 2022 онд 1,865.6 мянган төгрөг болж өслөө.

Зураг 2.1 ЕБС-ын нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлага, 2022 он




9-р ангийн суралцагчдын математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж хувь

Тархалтын хистограмаас харахад ихэнх аймаг буюу Дорноговь аймгаас Хөвсгөл аймаг хүртэл нийт 11 аймаг нь 2022 онд нэг суралцагчийг 1,620.0-1,860.0 мянган төгрөгөөр сургажээ.

<sup>26</sup> УХС 1212 тп: Тухайн оны үнээр, 2022 онд ДНБ 53,851,544.5 сая. төгрөг



Зураг 2.2 ЕБС-ийн нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлагын тархалт



Нэг суралцагчид ногдох урсгал төвийн зарлага

Аймаг, нийслэлээр тооцсон нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлагын дунжийн вариацийн коэффициент 2019 онд 19.4 хувь байсан бол ерөнхий боловсролын санхүүжилтийн тогтолцоонд шинэчлэлт хийсний үр дүнд 2022 оны гүйцэтгэлээр 15 хувь болж буурсан, харин нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлагын медиан хэмжээгээр тооцсон МакЛун индекс 85.1% болж өссөн байна.

### Хүснэгт 2.1 Санхүүжилтийн тэгш байдлын үзүүлэлт

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2022
Дундаж	1,250,760	1,324,671	1,314,792	1,488,614	<b>1,865,600</b>
Медиан	1,253,545	1,315,858	1,309,984	1,455,024	<b>1,847,000</b>
Стандарт хазайлт	179,735	205,505	206,407	246,382	<b>286,700</b>
Вариацийн коэффициент	16.7%	18.3%	18.3%	19.4%	<b>15.4%</b>
МакЛун Индекс	83.3%	82.7%	83.4%	84.1%	<b>85.1%</b>

## 2.2 Ерөнхий боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт

Ерөнхий боловсролын хөтөлбөрийн төлөвлөсөн үр дүнд хүрэхийн төлөө хэрэгжүүлсэн арга хэмжээ нэг бүрийн төсвийн зарлагын гүйцэтгэл, нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ, нэгжийн өртгийг тооцов.

2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн 682 сургууль үйл ажиллагаа явуулж 658,634 суралцагч хичээллэж, бага ангийн 10,316, дунд ангийн 20,874 багш ажилласан бол 2022-2023 оны хичээлийн жилд 688 сургууль үйл ажиллагаа явуулж, 683,708 суралцагч хичээллэж, бага ангийн 10,456, дунд ангийн 21,424 багш ажиллав.

2021-2023 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн 166 сургуульд 53,719 суралцагч хичээллэж, 3,954 багш ажилласан бол 2022-2023 оны хичээлийн жилд 171 сургуульд 62,697 суралцагч хичээллэж, 4,238 багш ажиллав.

Хүснэгт 2.2 ЕБ хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүний өртөг

Код	Арга хэмжээ	Бүтээгдэхүүнийг хэмжих үзүүлэлт, нэгж	2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/	Нэгжийн өртөг /мян.төг/
<b>Төлөөлөн гүйцэтгэх төрийн чиг үүргийн санхүүжилтийн арга хэмжээ</b>					
81834	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	Санхүүжих дундаж суралцагчдын тоо	667,576	791,770,840	1,163.7
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	Төрийн өмчийн сургуулийн тоо	688	83,966,478	122,044.3
80220	Байр ашиглалтын үйлчилгээ	Төрийн өмчийн сургуулийн тоо	688	6,115,743	8,782.0
80312	Сургалт семинар	Багш, удирдлагын тоо	32,520	1,368,677	42.3
81605	Эрүүл мэндийг дэмжих	Ажиллаж буй багшийн тоо	31,880	3,243,334	102.1
81801	Үдийн цай хөтөлбөр /хоол/	Бага ангийн хүүхдийн тоо	346,865	76,890,448	222.6
81806	Дотуур байрны үйлчилгээ	Дотуур байранд суусан хүүхдийн тооны дундаж	33,576	35,194,326	1,042.1
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	Санхүүжих дундаж суралцагчдын тоо	667,576	31,404,363	47.1
81823	Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	Мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо	10,826	6,716,599	622.1
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	Тэтгэмж авсан багшийн тоо	5161	58,149,178	11,267
80508	Төрийн бус өмчийн байгууллагад төсвөөс олгох дэмжлэг	Санхүүжих дундаж суралцагчдын тоо	57,021	29,855,890	523.6
<b>Дүн</b>				<b>1,124,675,877</b>	

Боловсрол, шинжлэх ухааны сайдын шууд хэрэгжүүлдэг арга хэмжээ

Код	Арга хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/
81804	Олимпиад зохион байгуулах	638,732
81823	Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	1,349,794.1
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	4,601,066.8
83303	ЕБС-д Олон улсын стандарт нэвтрүүлэх бэлтгэл хангах арга хэмжээ	2,217,750
81817	ЕБС-ийг сурах бичгээр хангах	6,653,758
<b>Дүн</b>		<b>15,461,101</b>

## Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Код	Арга хэмжээ	2022 оны зарлага /мян.төг/
1	Барилга байгууламж	173,651,452
2	Их засвар	4,230,402
3	Тоног төхөөрөмж	15,219,679
<b>Дүн</b>		<b>193,101,533</b>

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд ерөнхий боловсролын гурван чиглэлийн (сургалтын үр дүнгийн, дотоод үр ашиг, төгсөлтийн) нийт 17 үзүүлэлт батлагдсан<sup>27</sup> бөгөөд эдгээр үзүүлэлтийн гүйцэтгэлийг Боловсролын үнэлгээний төвийн гүйцэтгэлийн үнэлгээ болон боловсролын салбарын захиргааны статистикийн маягтаар гардаг хичээлийн жилийн тайланд үндэслэн тооцов.<sup>28</sup>

Ерөнхий боловсролын 2022 оны үр дүнгийн зорилтот түвшний ерөнхий биелэлт 94.4 хувь гарлаа.

Зураг 2.3 ЕБ-ын үр дүнгийн 2022 оны зорилтот түвшний биелэлт

Төрөл	Хэмжих Үзүүлэлт	2022 Оны Зорилтот Түвшин	2022 Оны Гүйцэтгэл	Биелэлт, %
Бага	Унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь	60	54.1	90.2%
	Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь	66	54.4	82.5%
	Дөрвөн хичээлийн жилийн өмнө 1-р ангид элссэн суралцагчдаас бага боловсрол эзэмшсэн хувь	98	99	101.1%
	Төгсөлтийн хувь, 11 настай хүн амаар	98	96.8	98.8%
Суурь	Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын хувь	63	58.8	93.5%
	Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын хувь	56	32.0	57.2%
	Гурван хичээлийн жилийн өмнө 6-р ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	98	99.4	101.4%
	Ахлах сургуульд элссэн хувь	82	82.2	100.3%
	Найман хичээлийн жилийн өмнө 1-р ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	96	95.7	99.8%
	Төгсөлтийн хувь, 15 настай хүн амаар	98	98.5	100.5%
БДБ	Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж	511	513	100.4%
	Хоёр хичээлийн жилийн өмнө 10-р ангид элссэн суралцагчдаас бүрэн дүнд боловсрол эзэмшсэн хувь	96	98	102.1%
	Бүрэн дүнд боловсрол эзэмшсэн хувь, 18 настай хүн амаар	79	78.0	98.8%

Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын хувь зорилтот түвшнээс нэлээд доогуур гарч байна. БШУЯ 2022 оны төсвийн

<sup>27</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16381595772311>

<sup>28</sup> Өгөгдлийг БШУЯ-ны esis.eu.mn-ээс авав.

саналыг бэлтгэхдээ аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дотоод үнэлгээнд үндэслэн суурь чадвар эзэмшсэн суралцагчдын хувийг 2019 онд тооцож түүнээсээ зорилт дэвшүүлсэн.

Боловсролын чанарын үнэлгээний тогтолцоонд шинэчлэл хийж Боловсролын үнэлгээний төвийн дотоод үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээгээр сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн гүйцэтгэлийн үнэлгээг 2022 оноос гаргадаг болсон. Энэ үнэлгээгээр Математикийн хичээлийн суурь чадвар эзэмшсэн 5 болон 9-р ангийн сурагчдын хувь аймаг, нийслэлийн БШУ-ны газрын дотоод үнэлгээгээр өмнө нь гаргасан үнэлгээнээс доогуур гарч байна.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын биет орчны өнөөгийн байдлыг харуулах 4 үзүүлэлтийн гүйцэтгэлийг гаргалаа. 2022 оны зорилтот түвшний биелэлт 91% байна.

Зураг 2.4 ЕБС-ын сургалтын орчны үзүүлэлтийн зорилтот түвшний биелэлт

Төрөл	Хэмжих Үзүүлэлт	2022 Оны Зорилтот Түвшин	2022 Оны Гүйцэтгэл	Биелэлт, %
Орчин	Сургалтын нэг компьютерийг ашиглах суралцагчийн тоо	24	25	97.2%
	Интернетэд холбогдсон сургалтын зориулалттай компьютерийн хувь	68	66.7	98.0%
	Нэг ээлжээр хичээллэх боломжтой сургуулийн хувь	45	36	79.9%
	Хүчин чадал ашиглалтын хувь	140	157	89.1%

Аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын 2022 оны үр дүнгийн өнөөгийн түвшинг улсын дундажтай харьцууля.

Зураг 2.5 Бага боловсролын 2022 оны үр дүнгийн үзүүлэлт, аймаг\_нийслэлээр

Аймаг_нийслэл	Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5-р ангийн сурагчдын хувь	Унших хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5-р ангийн сурагчдын хувь	2017-2018 онд 1-р ангид элссэн суралцагчдаас 2022 онд бага боловсрол эзэмшсэн хувь	2022 онд бага боловсрол эзэмшсэн 11 настай хүн амын хувь	Бага боловсролын үр дүнгийн үзүүлэлтийн дундаж	Бага боловсролын үр дүнгийн үзүүлэлтийн улсын дундажтай харьцуулсан хэлбэлзэл
Орхон	59.9%	60.5%	102.0%	104.2%	81.6%	5.5%
Улаанбаатар	62.0%	62.6%	101.8%	96.1%	80.6%	4.5%
Дархан-Уул	57.6%	57.7%	99.9%	102.9%	79.5%	3.4%
Хэнтий	57.2%	55.8%	101.9%	100.6%	78.9%	2.8%
Дорнод	58.7%	59.6%	98.0%	98.4%	78.7%	2.6%
Хөвсгөл	62.2%	60.3%	94.6%	95.9%	78.2%	2.1%
Завхан	53.5%	56.3%	95.1%	101.1%	76.5%	0.4%
Өмнөговь	53.6%	50.4%	103.2%	96.5%	75.9%	-0.2%
Төв	54.9%	54.5%	99.8%	93.1%	75.6%	-0.5%
Ховд	53.7%	55.8%	95.0%	97.8%	75.6%	-0.5%
Говьсүмбэр	49.4%	48.1%	99.0%	105.5%	75.5%	-0.6%
Сүхбаатар	51.7%	51.0%	98.0%	100.3%	75.2%	-0.9%
Архангай	57.1%	55.1%	94.2%	93.2%	74.9%	-1.2%
Говь-Алтай	55.6%	54.9%	93.8%	94.5%	74.7%	-1.4%
Увс	53.9%	57.7%	91.0%	95.7%	74.6%	-1.5%
Сэлэнгэ	53.6%	54.8%	96.5%	92.6%	74.4%	-1.7%
Дундговь	54.1%	49.9%	93.6%	99.9%	74.4%	-1.7%
Өвөрхангай	51.1%	50.6%	96.3%	99.2%	74.3%	-1.8%
Баян-Өлгий	51.9%	48.2%	95.0%	97.0%	73.0%	-3.1%
Дорноговь	47.9%	47.6%	95.7%	98.4%	72.4%	-3.7%
Булган	52.2%	52.0%	94.9%	89.8%	72.2%	-3.9%
Баянхонгор	45.9%	47.8%	95.8%	95.7%	71.3%	-4.8%

Зураг 2.6 Дунд боловсролын 2022 оны үр дүнгийн үзүүлэлт, аймаг\_нийслэлээр

Аймаг_нийслэл	Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9-р ангийн сурагчдын хувь	Унших хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9-р ангийн сурагчдын хувь	Үр дүнгийн бусад үзүүлэлтийн дундаж	Дунд боловсролын үр дүнгийн үзүүлэлтийн дундаж	Дунд боловсролын үр дүнгийн үзүүлэлтийн улсын дундажтай харьцуулсан хэлбэлзэл
Орхон	36.5%	60.2%	98.5%	81.8%	4.0%
Улаанбаатар	36.8%	61.3%	97.0%	81.0%	3.2%
Дархан-Уул	28.9%	60.5%	94.9%	78.1%	0.3%
Говь-Алтай	36.2%	63.0%	91.0%	77.2%	-0.6%
Дорнод	36.9%	57.9%	91.6%	76.8%	-1.0%
Хөвсгөл	32.7%	58.4%	92.4%	76.8%	-1.0%
Говьсүмбэр	28.1%	56.3%	94.1%	76.8%	-1.0%
Ховд	31.7%	59.9%	92.1%	76.7%	-1.1%
Архангай	35.1%	62.4%	90.5%	76.6%	-1.2%
Баян-Өлгий	29.0%	49.5%	94.9%	76.4%	-1.4%
Завхан	32.2%	60.5%	91.2%	76.2%	-1.6%
Өмнөговь	30.6%	58.7%	91.1%	75.6%	-2.2%
Сүхбаатар	28.2%	57.6%	91.6%	75.4%	-2.4%
Хэнтий	32.6%	60.4%	89.5%	75.2%	-2.6%
Булган	30.1%	57.7%	90.6%	75.0%	-2.8%
Төв	34.1%	62.5%	88.0%	74.8%	-3.0%
Өвөрхангай	33.6%	58.0%	89.2%	74.7%	-3.1%
Сэлэнгэ	32.3%	59.8%	88.8%	74.5%	-3.3%
Увс	34.4%	61.0%	87.6%	74.3%	-3.5%
Баянхонгор	28.6%	56.7%	89.1%	73.6%	-4.2%
Дундговь	29.4%	57.7%	87.4%	72.8%	-5.0%
Дорноговь	27.2%	55.7%	87.3%	72.0%	-5.8%

-10% -5% 0% 5%

Зураг 2.7 БДБ-ын 2022 оны үр дүнгийн үзүүлэлт, аймаг\_нийслэлээр

Аймаг_Нийслэл	2021-2022 оны хичээлийн жилийн ЕШ-ны хэмжээст онооны дундаж	2022 онд 18 настай хүн амаас бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	2019-2020 оны хичээлийн жилд ахлах сургуульд элссэн суралцагчдаас 2022 онд БДБ эзэмшсэн хувь	БДБ-ын үр дүнгийн үзүүлэлтийн дундаж	ЕШ-ын улсын дундажтай харьцуулсан хэлбэлзэл	Бүрэн дунд боловсролын үр дүнгийн үзүүлэлтийн улсын дундажтай харьцуулсан хэлбэлзэл
Баян-Өлгий	462	90.2%	110.8%	100.5%	-51	3.4%
Дархан-Уул	536	95.1%	101.9%	98.5%	23	1.4%
Ховд	507	90.0%	99.5%	94.8%	-6	-2.3%
Улаанбаатар	500	81.1%	107.6%	94.4%	-13	-2.7%
Орхон	535	89.9%	93.5%	91.7%	22	-5.4%
Говьсүмбэр	511	84.6%	94.4%	89.5%	-2	-7.6%
Дорнод	535	75.3%	98.6%	87.0%	22	-10.1%
Завхан	509	84.5%	88.7%	86.6%	-4	-10.5%
Говь-Алтай	512	80.7%	88.0%	84.3%	-1	-12.8%
Хөвсгөл	511	80.0%	88.6%	84.3%	-2	-12.8%
Архангай	499	77.8%	89.1%	83.5%	-14	-13.6%
Өвөрхангай	535	68.2%	94.4%	81.3%	22	-15.8%
Төв	512	65.3%	96.5%	80.9%	-1	-16.2%
Баянхонгор	500	60.7%	96.0%	78.4%	-13	-18.7%
Өмнөговь	513	62.8%	90.3%	76.5%	0	-20.6%
Дорноговь	510	62.8%	90.0%	76.4%	-3	-20.7%
Сүхбаатар	515	68.3%	82.6%	75.4%	2	-21.7%
Сэлэнгэ	514	69.0%	80.8%	74.9%	1	-22.2%
Увс	527	67.4%	80.2%	73.8%	14	-23.3%
Хэнтий	522	66.3%	77.6%	72.0%	9	-25.1%
Булган	507	66.5%	73.6%	70.1%	-6	-27.0%
Дундговь	501	58.8%	69.8%	64.3%	-12	-32.8%

-50 0 -40% -20% 0% 20%




Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийн биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтийг гаргав. “Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд бүх үзүүлэлтийн биелэлтийн хувь аль болох өндөр байх хэрэгтэй юм. Сонгосон үзүүлэлтээс 2025 оны дэвшүүлсэн зорилтод хүрэхэд хамгийн хол байгаа үзүүлэлт нь 9-р ангийн суралцагчдын математикийн хичээлийн сургалтын чанарыг харуулах үзүүлэлт байна.

### Зураг 2.8 ТХЗ 4-ийн шалгуур үзүүлэлтийн өнөөгийн түвшин

ТХЗ 4-ийн шалгуур үзүүлэлтийг төлөөлүүлэх үзүүлэлт

2022 оны түвшин, 2025 оны зорилт



### 3. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ

Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 71807 Тусгай хэрэгцээт боловсрол хөтөлбөр нь Боловсролын тухай хуулийн<sup>29</sup> 13.1-д заасан тэгш хамруулах боловсролын талаар төрөөс хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд чиглэнэ.

Монгол Улсын Засгийн газрын “Тэгш хамран сургах боловсролын талаар авах арга хэмжээний тухай”<sup>30</sup> тогтоолын дагуу “Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэл”-ийг<sup>31</sup> боловсруулж хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 21 аймаг, 9 дүүрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамран сургалтыг дэмжих зөвлөл” байгуулж, бүх сургуульд “Дэмжих баг” ажиллаж байна.

“Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”<sup>32</sup>-г баримталж ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрт зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах, хүүхдийн сурах орчин, тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын биет орчин бүрдүүлэх ажлыг хийж байна.

“Монгол брайл үсгийн стандарт” батлагдсанаар хараагүй иргэд нийгмийн харилцаанд бусад хүмүүсийн нэгэн адил тэгш оролцох, хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэдтэй брайл үсгээр дамжуулан харилцах, бие биедээ туслах, харилцан суралцах боломж бүрдэх суурийг тавьсан юм.<sup>33</sup> Багш нарт брайл үсгийн анхан шатны мэдлэг олгох, насан туршийн боловсролын төвөөр дамжуулан бичиг үсэг тайлагдаагүй харааны бэрхшээлтэй иргэдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлж байна.

БШУ-ны сайдын тушаалаар<sup>34</sup> баталсан “Мэргэжлийн чиглэл, индекс”-ийн нэгдүгээр төрөлжсөн чиглэлд багш, тусгай хэрэгцээт боловсрол бакалавр, магистр чиглэл багтсан. 2022 онд багш, тусгай хэрэгцээт боловсролоор 68 оюутан, тусгай хэрэгцээт боловсролоор 7 оюутан суралцаж байна. Мөн ОХУ-ын Буриадын багшийн дээд сургуулиас хөрвөх сургалтаар хэл засалч мэргэжлээр 45 багш төгсөв. 2022-2023 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдээс АШУҮИС-ийн Сувилахуйн сургуульд хөдөлгөөн засалчаар 7, хөдөлмөр засалчаар 12 хүн сурч байна. Мөн тэгш хамран сургах боловсролын арга зүйн сургалтыг тасралтгүй явуулж байна.<sup>35</sup>

<sup>29</sup> Хуучин хуулиар

<sup>30</sup> Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 235-р тогтоол

<sup>31</sup> БШУ-ны Сайдын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/553 тоот тушаал

<sup>32</sup> БШУ-ны Сайдын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/206 тоот тушаал

<sup>33</sup> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2020) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа

<sup>34</sup> БШУ-ны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” 2022 оны А/160 дугаар тушаал

<sup>35</sup> Жишээ нь багш нарт оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэжил, арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, оюуны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сургалтад Өмнөговь, Ховд аймгийн сургуулийн дэмжлэгийн багийн гишүүд, сургалтын менежер, нийгмийн ажилтан хамрагдлаа. Боловсролын ерөнхий газар, Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоотой хамтран “Арт терапи” буюу урлагаар дамжуулж хүүхдийн сэтгэл хөдлөл, мэдрэмжийг хөгжүүлэх чиглэлээр



### 3.1 Тусгай хэрэгцээт боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм

Суралцагчдад учирч байгаа, учирч болзошгүй саад бэрхшээлийг багасгах, арилгах, даван туулахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх, тухайн шатны боловсролын суралцахуйн зорилгод хүрэхийн тулд тохируулга хийсэн сурганы арга зүй бүхий сургалт, хөгжлийн болон дэмжин туслах үйл ажиллагааг Тусгай хэрэгцээт хөтөлбөрөөр хэрэгжүүлдэг.

Боловсролын багц хуулиар батлагдсан тэгш хамруулах бодлого буюу ердийн ерөнхий боловсролын сургуульд ялгаатай хэрэгцээтэй суралцагчдыг хамруулах бодлогыг хэрэгжүүлж байна. Тэгш хамруулах бодлогыг бүрэн хэрэгжүүлж хэвштэл тусгай сургуулийн үйл ажиллагаа болон ерөнхий боловсролын ердийн сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй эсвэл ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад үзүүлэх тусламж, дэмжлэг, боловсрол сургалтын нэмэлт үйлчилгээнд хяналт тавих зорилгоор энэ хөтөлбөрийг хэвээр үлдээх шаардлагатай байгаа юм.

Тусгай хэрэгцээт боловсрол хөтөлбөр дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг 6 сургуулийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг тайлагнадаг. 2022 онд эдгээр сургуулийн урсгал төсвийн зарлагад 12,650.0 сая төгрөг зарцуулж, нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлага дунджаар 7.5 сая төгрөг байна.

#### Хүснэгт 3.1 Тусгай боловсролын сургуулийн урсгал төсвийн зарлагын гүйцэтгэл

Байгууллага	Дүүрэг	2022 оны санхүүжсэн суралцагчдын дундаж тоо	Нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлага /мян.төг/
55-р сургууль /Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй/	Баянзүрх	488	5,689.9
63-р сургууль /Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй/	Хан-уул	283	5,806.3
25-р сургууль /Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй/	Сүхбаатар	194	10,058.5
116-р сургууль /Харааны бэрхшээлтэй/	Сүхбаатар-Яам шууд	129	13,256.5
70-р сургууль /оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй/	Баянгол	318	4,553.0
29- дүгээр сургууль /Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй/	Сүхбаатар-Яам шууд	272	11,474.0
Дундаж		1,684	7,511.9
Стандарт хазайлт			3,281.3

*багш, сурагчид, эцэг эхчүүдээс сургагч багш буюу "Ментор багш" бэлтгэн 238 хүнийг хамруулав. Тэгш хамран сургах боловсролын талаарх сургалтын хэрэгцээний судалгааг аймаг/дүүргийн 336 багш, 25 удирдах ажилтнаас авч сургалтын хөтөлбөр, сургалтын материал боловсруулан 400 багш, 20 удирдах ажилтныг сургалтад хамруулав. Мөн "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах төсөл"-ийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг, Өмнөговь аймгийн тэгш хамруулах боловсролын 45 мэргэжилтнийг сургалтад хамруулж, Брайл бичиг, технологийн сургалтаар 10 багш, дохионы хэлний сургалтаар 11 багшийг чадавхжуулав.*



### 3.2 Тусгай хэрэгцээт боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт

Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилийн тайлангаар цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй 1,498 хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 9,012 суралцагч суралцаж байна.


#### Хүснэгт 3.2 Хамран сургалтын тооцсон хувь

Хүн ам	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусын тоо /2020 оны байдлаар/	Тухайн насны хүн амын хувь	Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам /2022 оны тооцсон/	Боловсролд хамрагдсан суралцагчдын тоо /2022-2023 оны хичээлийн жилд/	Хамран сургалтын хувь
2-5 настай	1,585	0.6%	1,753	1,498	85.4%
6-17 настай	8,209	1.13%	9,012	5,673	63%

Эх сурвалж: Эхний хоёр баганыг "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2020) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа"-судалгаанаас

Төсвийн нийт урсгал зарлагаас сургалттай холбоотой шууд зардлыг ялгаж суралцагчдын ялгаатай хэрэгцээг санхүүжүүлж буй орцыг хэмждэг. Нэг суралцагчид ногдох сургалтын үйл ажиллагааны шууд зардал тусгай хэрэгцээт боловсролын хувьд өндөр хэвээр байгаа нь боловсролын санхүүжилтийн үндсэн зарчмын нэг босоо чиглэлээр тэгш байдал алдагдаагүй гэдгийг харуулна.

#### Зураг 3.1 Нэг суралцагчид ногдох сургалтын дундаж зардал (мян.төг)



Жил

---

## 4. НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ

Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 71806 Насан туршийн боловсрол хөтөлбөр нь Боловсролын тухай хуулийн<sup>36</sup> 3.1.20, 39.6, Бага, дунд боловсролын тухай хуулийн<sup>37</sup> 12.5-д заасан үйлчилгээг иргэдэд хүргэх зориулалттай.

Дунд хугацаанд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.1.10, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.12-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

### 4.1 Насан туршийн боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм

Насан туршийн боловсролд 2022 онд 5.4 тэрбум төгрөг улсын төсвөөс зарцуулж, төсвийн гүйцэтгэл 99.5 хувь байна. Насан туршийн боловсролын 2022 оны төсвийн урсгал зарлагын 90 хувийг дүйцсэн хөтөлбөрөөр ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх үйл ажиллагаанд зарцууллаа.

Насан туршийн боловсрол төв<sup>38</sup> нь тухайн орон нутгийнхаа насанд хүрсэн хүн ам болон сургууль завсардсан эсвэл тусгайлсан дэмжлэг туслалцаа хэрэгтэй байгаа сургуулийн насны хүн амд боловсролын үйлчилгээ, мөн нийт хүн амд насан туршийн суралцахуйн талаар зөвлөн туслах, зуучлах үйлчилгээ үзүүлдэг. 2022 онд 9 дүүрэг 21 аймагт 30 төв үйл ажиллагаа явуулж НТБ-ын төвд 370 хүн, сургууль дээрх төвтэй нийлээд нийт 623 хүн ажиллав.

### 4.2 Насан туршийн боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт

Насан туршийн боловсролын төвийн зохион байгуулсан, зуучилсан, хамтран ажилласан 8 төрлийн сургалтад 2022 онд нийт 231,154 хүн хамрагдаж аймаг, нийслэлийн 18-аас дээш насны хүн амын хамран сургалтаар Дундговь аймаг тэргүүлж байна. Тус аймаг 2022 онд нийт 11,050 хүн хамруулснаас 10,997 нь 18-аас дээш насны хүн ам буюу тус аймгийн 18-аас дээш насны хүн амын 36 хувь нь сургалтад хамрагджээ.


---

<sup>36</sup> Хуучин хуулиар

<sup>37</sup> Хуучин хуулиар

<sup>38</sup> Хуучин нэрээр

Зураг 4.1 Хүн амын сургалтад хамрагдсан байдал



Эх сурвалж: БЕГ-ийн Насан туршийн боловсролын хэлтэс

Дүйцсэн хөтөлбөрөөр 2021-2022 оны хичээлийн жилд 4,964, 2022-2023 оны хичээлийн жилд 4,981 суралцагчид ерөнхий боловсрол нөхөж олгохоор ажиллав.<sup>39</sup>

Хүснэгт 4.1 НТБ хөтөлбөрийн хүрээнд 2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүний өртөг

Код	Арга хэмжээ	Бүтээгдэхүүнийг хэмжих үзүүлэлт, нэгж	2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/	Нэгжийн өртөг /мян.төг/
81834	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	Дүйцсэн хөтөлбөрөөр санхүүжсэн дундаж суралцагчдын тоо	4,971	4,863,568.4	978.4
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	Насан туршийн боловсролын төвийн тоо	30	559,233.2	18,641.1
81823	Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	Мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо	11	5,000.0	454.5
			<b>Дүн</b>	<b>5,427,801.6</b>	

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр,

<sup>39</sup> Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хүний тоонд ЕБС-ийн орой, эчнээгээр хичээллэж буй суралцагчдын тоог нэгтгэн тооцов.

хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд насан туршийн боловсролын хоёр (2) үзүүлэлт батлагдсан.<sup>40</sup>

Насан туршийн боловсролын 2022 оны үр дүнгийн зорилтот түвшний ерөнхий биелэлт 91.6 хувь гарлаа.

ҮСХ-ноос 2018 онд хийсэн Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд 15-49 насны хүн амын мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ) ашиглахтай холбоотой үйлдэл хийсэн (ашиглах чадвартай) хүн ам дунджаар 17 хувь гэж тооцсон. Энэ судалгаагаар 15-49 насны хүн амын 31 хувь нь МХХТ-ийн 9 үйлдлээс аль нэгийг нь хийсэн байна.<sup>41</sup>

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадвар эзэмшсэн 18-аас дээш насны нийт хүн амын хувийг Алсын хараа 2050-д заасан зорилтод (2025 онд) хүргэхийн тулд жилд 105.0 мянган хүнийг сургалтад хамруулах шаардлагатай байгаа. 2020 онд 2.2, 2021 онд 4.5, 2022 онд 5.7 хувь буюу 18-аас дээш насны нийт хүн амын 12.4 хувийг ямар нэг хэлбэрийн МХХТ-ийн хэрэглээний чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулаад байна.<sup>42</sup>

#### Хүснэгт 4.2 НТБ хөтөлбөрийн үр дүнгийн зорилтот түвшний биелэлт

Хэмжих үзүүлэлт	Хэмжих цаг хугацаа	2022 оны зорилт	2022 оны гүйцэтгэл	Биелэлт
Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадвар эзэмшсэн хүн амын хувь, 18-аас дээш настай хүн амаар	2020-2022 он хүртэл сургалтад хамрагдсан хүний тоо болон тухай насны хүн амд эзлэх хувь	15	<b>12.4%</b>	<b>82.5%</b>
Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хүний тоо	Санхүүжсэн суралцагчдын тооны дундаж	5068 <sup>43</sup>	5103	<b>100.7%</b>



Тухайн жилд хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны хүн амын хувь нь тухайн улсын боловсролын системийн үр дүнг харуулах чухал үзүүлэлтийн нэг болдог.

Хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны хүн амын хувийг ҮСХ-оос жил бүр гаргадаг. Манай улсын хувьд энэ үзүүлэлт харьцангуй өндөр, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд өндөр байсаар ирлээ.<sup>44</sup>

Хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны хүн амын хувийг бууруулах нь боловсролын системийн нэг мөчлөгийн (кохорт) дотоод

<sup>40</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=1638159577231>

<sup>41</sup> ҮСХ (2018) Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа


<sup>42</sup> "И-Монгол академи" УТУГ-аас бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна.

<sup>43</sup> Орой, эчнээ сургалтаар ерөнхий боловсрол нөхөн эзэмшсэн суралцагчдыг оруулж тооцов.

<sup>44</sup> Among economies with available data in East Asia, the Republic of Korea and Mongolia recorded the highest youth NEET rates as of 2019, at 12.5 per cent and 18.5 per cent, respectively. ILO

үр ашгийг дээшлүүлэх тухай асуудал учраас урт хугацааны хяналт шаардлагатай байна. Бид сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын хамран сургалт, төгсөлтийг мөшгөх судалгаа хийж хүн амын боловсрол эзэмшилтийн үр дүнг хянаж байгааг өмнөх бүлгүүдээс Та бүхэн харлаа. Сүүлийн хоёр жил энэ хувь дараалан буурсан байна.

Зураг 4.2 Хөдөлмөр эрхэлээгүй, сургуульд сураагүй байгаа 15-24 насны залуусын хувь



Эх сурвалж: YCX 1212 тп 8.6.1 Хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны залуучуудын эзлэх хувь

---

## 5. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ

71804 Мэргэжлийн боловсрол хөтөлбөр нь Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд<sup>45</sup> заасан үйлчилгээг иргэдэд хүргэх зориулалттай.

Мөн “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын Хоёр. Хүний хөгжил хэсэгт дэвшүүлсэн зорилтод хүрэх, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.1.3-2.1.6, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.5, 2.3.15-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Засгийн газрын урт болон дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн боловсролын салбарт 2022 онд хийсэн ажил, хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дараах ажлыг онцолж байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт 2022-2023 оны хичээлийн жилд нийтдээ 210 хөтөлбөрөөр хичээл сургалтын үйл ажиллагаа эрхэлж, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжил дэвшлийг дагаж 2-3 жил тутам хөтөлбөрийн агуулга өөрчлөгдөж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.2.3 дэх хэсгийг үндэслэн “ажил мэргэжлийн стандарт”-ыг олон улсад ажил мэргэжлийн стандарт боловсруулах аргачлал, арга зүйд нийцүүлэн боловсруулж батлуулав.<sup>46</sup> Үүнийг сургалтын хөтөлбөрийн агуулгад тусган хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хөгжүүлж, нэвтрүүлсэн мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн систем (mergejil.mn)-ийг хүлээн авч, шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг Боловсролын мэдээллийн технологийн төв (www.tvets.edu.mn) хийв. Тус шинэчлэлийн хүрээнд суралцагч, багш, ажилтны бүртгэлийг сайжруулж, системд бүртгэлтэй суралцагчийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн систем болон дээд боловсролын удирдлага мэдээллийн системийн мэдээллийн сантай холбосноор ерөнхий боловсрол болон дээд боловсролын сургалтын байгууллагад давхар бүртгэлтэй эсэхийг хянах боломжтой боллоо. Үүний дүнд регистрийн дугаар алдаатай 1,383, систем дотроо давхардсан 323, боловсролын салбарын мэдээллийн системтэй давхардсан 570, дээд боловсролын удирдлага мэдээллийн системтэй давхардсан 4,121 суралцагчийн мэдээллийг залруулж, давхардлыг арилган бүртгэлийг шинэчилж 2021-2022 оны хичээлийн жилд төгсөгчдийн бичиг баримтыг системээр хэвлэн баталгаажуулж олгов. Мөн “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”<sup>47</sup>-д нийцүүлэн суралцагчийг төгсөх үед нь нэг удаа тэтгэлэг олгох болон мэргэжлийн

---

<sup>45</sup> Хуучин хуулиар

<sup>46</sup> Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн үндэсний хорооны 2022 оны 4 дүгээр тогтоол

<sup>47</sup> Засгийн газрын 2022 оны 122 дугаар тогтоол

---

боловсрол, сургалтын байгууллагад шинээр элсэгчийг бүртгэх үед боловсролын салбарын бусад мэдээллийн системээс суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшсэн, их, дээд сургуульд суралцаж байгаа эсэхийг шалгах үйлчилгээний шалгуур, хяналтын хэсгийн нэмэлт хөгжүүлэлтийг хийв.

Салбар дундын дадлагын баазыг мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагыг түшиглэн чадамжийн төв хэлбэрээр хөгжүүлэхээр нийт 10 төвийг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн түншлэлд суурилсан мэргэжлийн боловсролын сургалтын төсөл, Азийн хөгжлийн банкны Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дэмжих төслийн дэмжлэгтэйгээр байгуулав.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг бүс орон нутгийн хөгжлийн чиг хандлага, ногоон хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан төрөлжсөн салбар дундын үйлдвэрлэл, дадлагын баазыг “чадамжийн төв”, шинэ хотхоныг кластер хэлбэрээр байгуулж хөгжүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа Технологийн дээд сургуулийг Өмнөговь Политехник коллежтэй Орхон аймагт Эрдэнэт технологийн дээд сургуулийг мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагатай кластер хэлбэрээр ажиллуулахаар төлөвлөв. Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа Технологийн дээд сургуулийг байгуулж, 2022-2023 оны хичээлийн жилд 120 оюутантайгаар сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн.<sup>48</sup> Өмнөговь аймагт дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 3000 оюутны хүчин чадал бүхий “Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулахаар Оюу толгой ХХК-тай хөрөнгө оруулалтын санамж бичиг байгуулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.

“Дэлхийн ур чадвар” олон улсын тэмцээн 2022 оны 10-11 дүгээр сард 61 мэргэжлээр явагдаж 58 улсын 1000 гаруй оролцогчид өрсөлдлөө. Манай улс токарь, гагнуур, ерөг угсралт, сантехник, тогооч, мужаан, цахилгаан угсралт зэрэг 7 төрөлд өрсөлдөж амжилттай оролцлоо.

## **5.1 Мэргэжлийн боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм**

Мэргэжлийн боловсролын урсгал зардалд 2022 онд 87,492 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 80,441.8 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 92 хувь байна. Мөн хөрөнгө оруулалтад 439.8 сая төгрөг зарцууллаа. Мэргэжлийн боловсролд 2022 онд нийтдээ ДНБ-ны 0.15 хувийг зарцуулсан байна.

Төрийн өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн<sup>49</sup> нэг суралцагчид зарцуулсан урсгал төсвийн зарлага дунджаар 2,667.0 мянган төгрөг, стандарт хазайлт 1,095.0 мянган төгрөг байна.


Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив батлах тухай” 200 дугаар тогтоолоор мэргэжлийн боловсролын санхүүжилтийн тогтолцоонд өөрчлөлт хийв.

---

<sup>48</sup> Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоол

<sup>49</sup> Хуучин нэрээр

Зураг 5.1 МБС-ын нэг суралцагчид ногдох төсвийн урсгал зарлага, хөдөлмөр эрхлэлтийн хамаарал



## 5.2 Мэргэжлийн боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт

2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын 48, төрийн бус өмчийн 30 сургууль үйл ажиллагаа явуулж нийт 38,034 хүн суралцав.

Хүснэгт 5.1 МБ хөтөлбөрийн хүрээнд 2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүний өртөг

Код	Арга хэмжээ	Бүтээгдэхүүнийг хэмжих үзүүлэлт, нэгж	2022 онд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/	Нэгжийн өртөг /мян.төг/
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	Санхүүжих дундаж суралцагчдын тоо	32,333	56,337,779.5	1,952.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	Ажиллаж буй хүний тоо	4,094	3,708,695.5	905.9
81806	Дотуур байрны үйлчилгээ	Дотуур байранд амьдарч буй сурагцагчдын тоо	3,942	2,329,808.5	591.0
81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	Санхүүжих дундаж суралцагчдын тоо	14,141	6,805,313	481.2
	/Хувийн МСУТ-д олгосон санхүүжилт/				
81808	МСУТ-д суралцагсадад сар тутам олгох тэтгэлэг	Тэтгэмж авсан хүний тоо	10,467	11,260,200	1,075.7
<b>Дүн</b>				<b>80,441,796.8</b>	



Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд мэргэжлийн боловсролын гурван (3) үзүүлэлт батлагдсан<sup>50</sup> бөгөөд эдгээр үзүүлэлтийн гүйцэтгэлийг хичээлийн жилийн тайланд үндэслэн тооцов.

Мэргэжлийн боловсролын үр дүнгийн 2022 оны зорилтот түвшний ерөнхий биелэлт 98.1 хувь гарлаа.

2021-2022 оны хичээлийн жилийн тайлангаар нийт 22,251 суралцагч Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төгсөж, 11,488 төгсөгч буюу төгсөгчдийн 51.6% нь төгсөнгүүтээ шууд хөдөлмөр эрхэлж, 1,598 буюу 7.2% нь дараагийн шатны сургуульд дэвшин суралцсан байна.

*Хүснэгт 5.2 НТБ-ын 2022 оны үр дүнгийн зорилтот түвшний биелэлт*

Хэмжих үзүүлэлт	Хэмжих цаг хугацаа	2022 оны зорилтот түвшин	2022 оны гүйцэтгэл	Биелэлт, %
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь	2022-2023 оны хичээлийн жил	1.87	1.75	<b>93.6%</b>
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь	2021-2022 оны хичээлийн жил	68	58.8	<b>86.5%</b>
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчныг стандартад нийцүүлэх хувь	2022-2023 оны хичээлийн жил	70	80	<b>114.3%</b>

<sup>50</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=1638159577231>

---

## 6. ДЭЭД БОЛОВСРОЛ

71803 Дээд боловсрол хөтөлбөр нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуульд заасан үйлчилгээг иргэдэд хүргэх зориулалттай.

Дунд хугацаанд “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын Хоёр. Хүний хөгжил хэсэгт дэвшүүлсэн зорилтод хүрэх, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.1.4-2.1.6, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.5-2.3.7, 2.3.14-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Дээд боловсролын салбарт 2022 онд хийсэн ажил, хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дараах ажлыг онцолж байна.

Бусад улсын туршлагыг судалж өөрийн орны онцлогийг тусган “Мэргэшлийн үндэсний хүрээ”-г 10 түвшинтэйгээр боловсрууллаа. Дээд боловсрол нь Мэргэшлийн үндэсний хүрээний 7-10 дугаар түвшинд харгалзах ба 3 жил суралцаж дипломын боловсрол эзэмшсэн суралцагч Мэргэшлийн үндэсний хүрээний 7 дугаар түвшний мэргэшлийн чадамжтай байна. Бакалаврын зэргээр төгсөгч нь Мэргэшлийн үндэсний хүрээний 8 дугаар түвшний мэргэшлийн чадамжтай байна. Магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөрөөр төгсөгч нь Мэргэшлийн үндэсний хүрээний 9 дүгээр түвшний мэргэшлийн чадамжтай байна. Мэргэшлийн үндэсний хүрээний хамгийн дээд түвшин буюу 10 дугаар түвшин нь докторын зэргийн сургалтын төгсөгчдөд хамаарахаар түвшин тус бүрийн мэдлэг, чадварын шалгуурыг боловсруулан тусгав.

Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын дэргэд 25 гарааны компани йл ажиллагаагаа явуулж байна. Шинжлэх ухааны академийн дэргэд Технологийн Инкубатор ХХК биотехнологи, микробиологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, технологийн хөгжүүлэлт хийж байна. МУИС, ШУТИС, АШУҮИС, ХААИС-ийн дэргэд Инноваци, технологи дамжуулах төвүүд байгуулагдан үйл ажиллагаа нь жигдэрлээ. Эдгээр төвүүд нь багш, судлаачид, оюутан, зохион бүтээгчдийн ноухау, судалгааны үр дүнг оюуны өмчийн эрхийн хамгаалалтаар баталгаажуулан эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. 2022 оны 9 дүгээр сарын байдлаар төрийн өмчит 7 их сургууль (МУИС, ШУТИС, АШУҮИС, ХААИС, МУБИС, ҮБХИС, ХСИС)-ийн дэргэд 103 туршилт, судалгааны лаборатори тухайн шинжлэх ухааны салбар бүрээр судалгаа шинжилгээ, туршилт хийж байна.

Техникийн шаардлага хангасан судалгааны нээлттэй, дундын болон сүлжээ лабораторийн стандарт, эрх зүйн байдлын судалгааг Монгол улсад үйл ажиллагааны явуулж буй 54 байгууллагын 311 лабораторийг хамруулан хийв. Энэ судалгаагаар лабораториудын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж цаашид авч хэрэгжүүлэх бодлого боловсрууллаа.

---

Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд 4.8 га талбай бүхий газарт 72,000 м.кв ашиглалтын талбайтай, оффис, лаборатори, музей, хэвлэх үйлдвэр, агуулах, спорт цогцолбортой шинжлэх ухаан, технологи, инновацын кластерын 7 блок барилгын ажил явагдаж байна. Кластерын<sup>51</sup> барилгын лабораторийн 3 корпус бүрэн ашиглалтад орсноор судалгаа хийх олон улсын стандартын шаардлагыг хангасан нэгдсэн сүлжээ лабораториуд бүрэн хүчин чадлаар ажиллана.

“Оюутан элсүүлэх журам”<sup>52</sup>-ын дагуу 2022-2023 оны хичээлийн жилд их, дээд сургуульд элсэгчдээс авах Элсэлтийн ерөнхий шалгалтыг жилд хоёр удаа зохион байгуулахаар шийдвэрлэв. 6 дугаар сард зохион байгуулсан ЭЕШ-д 36,259 шалгуулагч бүртгүүлж, шалгалтад 49 багийн ахлагч, 49 сэдэв хариуцагч, 49 хянагч багшийн ахлагч, 4500 хянагч багш ажиллаа. Мөн МУИС-тай хамтран ЭЕШ өгөхөөр бэлтгэж буй суралцагчдад 10 судлагдахууны хичээлээр “Мэргэжилтэн зөвлөж байна” 50 цахим контент, 8-9, 10-11, 12 дугаар ангийн сурагчдад “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” 5 цахим контентыг тус тус боловсруулан цахим сайт, пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж, шалгуулагчдын сэтгэл зүйг дэмжих ЧАТБОТ үйлчилгээг онлайнгаар үзүүлэв.

“Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол улсын ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэн тооцох тухай” журам<sup>53</sup>-ын дагуу их, дээд сургуулийн элсэлтийн шалгалт нь төгсөлтийн шалгалттай нэгдмэл байдаг гадаадын ахлах сургууль төгссөн болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрөөр суралцаж төгссөн суралцагчдын сурлагын дүн, оноо,<sup>54</sup> мөн гадаад улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг олон улсын шалгалтын оноог<sup>55</sup> элсэлтийн ерөнхий шалгалтын оноонд дүйцүүлэх 300 гаруй суралцагчийн хүсэлтийг цахимаар авч, 100 орчим суралцагчийн олон улсын шалгалтын дүн, оноог ЭЕШ-ын оноонд шилжүүлэв.

Бусад улсын жишиг, туршлагыг судалж<sup>56</sup> судалгаанд суурилсан их сургуульд тавигдах шаардлага, шалгуурыг 3 чиглэлийн (ахисан түвшний сургалтын хөтөлбөр, судалгааны ажлын үр дүн, боловсон хүчний чадавх) 8 шалгуур үзүүлэлтээр боловсрууллаа.

БШУ-ны сайдын тушаалаар<sup>57</sup> “Мэргэжлийн чиглэл, индекс”-ийг шинэчлэн баталж олон улсын жишигт нийцүүлэн МХХТ-ийн хиймэл оюун ухаан, өгөгдлийн ухаан, мэдээллийн аюулгүй байдал, IoT зэрэг 13 мэргэжлийн индекс, 10 чиглэлээр 453 мэргэжлийн жагсаалт батлав.<sup>58</sup>

---

<sup>51</sup> Одоогийн нэршлээр “нэгдсэн цогцолбор”

<sup>52</sup> БШУ-ны сайдын 2013 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/79 дүгээр тушаал

<sup>53</sup> Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 1 дүгээр хэсгийн 1.2 дахь заалт, “Оюутан элсүүлэх журам, БШУ-ны сайдын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн А/347 дугаар тушаал

<sup>54</sup> Кембрижийн IGCSE, O, AS, A, IB- International Baccalaureate, AP- Advanced Placement

<sup>55</sup> TOEFL, IELTS, SAT

<sup>56</sup> Казахстан, ОХУ, БНХАУ, Япон, АНУ зэрэг

<sup>57</sup> БШУ-ны сайдын 2022 оны 160 дугаар тушаал

<sup>58</sup> Уг тушаалаар 051 индекстэй “Биологи ба холбогдох шинжлэх ухаан” ерөнхий чиглэлд “051102 Микробиологи”, “051202 Биотехнологи”, 078 индекстэй инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламжид хамаарах салбар дундын чиглэлд “078801 Нано шинжлэх ухаан, инженерчлэл”, 091 индекстэй “Эрүүл мэнд” ерөнхий чиглэлд “091210 Молекул биологи”, “091401 Био анагаах ухаан” мэргэжлийн чиглэл оруулав.

---

2022-2023 оны хичээлийн жилд молекул биологи сургалтын хөтөлбөрт 65 суралцагч, биотехнологи сургалтын хөтөлбөрт 2,068 суралцагч, нано шинжлэх ухаан, инженерчлэл сургалтын хөтөлбөрт 179 суралцагч суралцаж байна. Мөн ШУТИС-д Мультимедиа технологи, өгөгдлийн сан, хиймэл оюун ухаан, IoT технологи, робот ба хиймэл оюун ухаан, Ухаалаг сүлжээ гэсэн мэргэжил шинээр нээж 2021-2022 хичээлийн жилд элсэлт авч, мэргэжилтэн бэлтгэж эхэллээ.<sup>59</sup>

Дээд боловсролын салбарын 2022-2023 хичээлийн жилийн статистик мэдээллээр МХХТ-ийн салбарын чиглэлийн 10,660 оюутан 22 мэргэжлээр суралцаж байна.<sup>60</sup>

Шинжлэх ухаан, технологийн сангаас төр, хувийн өмчийн 8 их, дээд сургуулийн судалгааны багуудын 79 төсөлд санхүүжилт олголоо. Үүнд ШУТИС-ийн 18 төсөл, ХААИС-ийн 15 төсөл, МУИС-ийн 31 төсөл, АШУҮИС-ийн 9 төсөл, Ач АУИС-ийн 1 төсөл, Ховд их сургуулийн 3 төсөл, Улаанбаатар их сургуулийн 1 төсөл, Улаанбаатар-Эрдэм их сургуульд 1 төсөл багтжээ.

Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл (7,5 тэрбум иен) болон Монгол Улсын төсвийн санхүүжилтээр (615 сая иен) хэрэгжиж байгаа “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд Монгол Улсын их сургууль болон Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн сургалтын тоног, төхөөрөмж, лабораторийг шинэчлэх, хүртээмжийг сайжруулах зорилгоор 253 нэр төрлийн төхөөрөмж нийлүүлж, Монгол Улсын их сургууль болон Шинжлэх ухаан, технологийн их сургуулиас тус бүр судалгааны баг шалгаруулан 384 багш, судлаачид Япон Улсын 40 гаруй их сургууль, хүрээлэнгийн судлаачидтай хамтран Монгол Улсад нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэж байна. Эдгээр хамтарсан судалгааны багуудын судалгааны ажлын үр дүнд өссөн дүнгээр Олон Улсын сэтгүүлд 335 өгүүлэл, дотоодын сэтгүүлд 267 өгүүлэл хэвлүүлж, 37 бүтээлийг оюуны өмчийг бүртгүүлж, гарааны 3 компани үйл ажиллагаа явуулж байна.

БНЭУ-н санхүүжилтээр хэрэгжиж буй Мэдээллийн технологи, аутсорсингийн төслийн 2-р багцын хүрээнд МХХТ-ийн инженер, оюутан залуус, багш нарын чадавхыг бэхжүүлэх 16 хөтөлбөрөөр ШУТИС-дээр сургалт зохион байгуулж байна.<sup>61</sup>

БШУ-ны сайдын тушаалаар<sup>62</sup> 21 их, дээд сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, ЗГ-ын 2022 оны 293 тогтоолоор төрийн өмчийн зарим их, дээд сургуулийг нэгтгэлээ. Багш мэргэжлээр өндөр оноотой элсэгч 1291 оюутанд 1,455.1 сая төгрөг, 4,533 сувилагч мэргэжлээр суралцагчид 4,754.8 сая төгрөгийн тэтгэлэг олгов.

---

<sup>59</sup> БШУ-ны Сайдын 2021 оны “Шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай” А/174 дүгээр тушаал

<sup>60</sup> Үүнд системийн аюулгүй байдал-578, Кибер аюулгүй байдал-139, Өгөгдлийн ухаан-111, Виртуал сургалтын систем-5, IT технологи/зүйлсийн интернэт-79, Хиймэл оюун ухаан-104 оюутан суралцаж байна.

<sup>61</sup> Linux Training, DATA Visualization, AI & ML, DATA Analytics, VMware, iOS, Java, Soft Skills, Soft Test, BPO-д 386 суралцагч хамрагдав. Data Analytics, Cyber Security-гийн чиглэлээр БНЭУ-д зохион байгуулсан 45 хоногийн танхимын сургалтад 15 хүн хамрагдав.

<sup>62</sup> БШУ-ны Сайдын 2022 оны А/296 тушаал

## 6.1 Дээд боловсролын 2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн тойм

Дээд боловсролын урсгал зардалд 2022 онд 57,919.2 сая төгрөг, хөрөнгө оруулалтад 2,566.2 сая төгрөг зарцуулж, энэ нь ДНБ-ны 0.11% болж байна. Дээд боловсролын төсвийн зарлагын 89 хувийг иргэдэд дээд боловсрол эзэмших тэгш боломж олгоход болон оюутны тэтгэлэг, зээл, хөнгөлөлтөд зарцуулжээ.

Хүснэгт 6.1 Дээд боловсролын төсвийн зарлага, бүтээгдэхүүний өртөг

Код	Арга хэмжээ	2022 оны гүйцэтгэл-хамрагдсан хүний тоо	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/
81812	Засгийн газрын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг	271	844,543
81813	Бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлт, 3 хүүхэд нь зэрэг суралцдаг суралцагчдад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэг	4,819	13,238,877
81814	Орон нутгаас суралцаж буй оюутнуудын замын зардлын хөнгөлөлт	5,993	744,520
81826	Багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантуудад олгох сургалтын төлбөр	1,291	1,455,125
81828	Орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг	520	343,228
81846	Оюутны хөгжлийн зээл	4,876	14,170,475
81849	Сувилагч мэргэжлээр төрийн өмчийн их дээд сургуульд суралцагсдын тэтгэлэг	4,533	5,739,752
81851	Гадаадад суралцагсдын зээл	145	8,861,441
81852	ЗГ-н гэрээгээр гадаадад суралцагсдын тэтгэлэг	157	3,288,469
81853	Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгийн хүрээнд олгох Бэлтгэл хөтөлбөрийн хэрэгжилт	302	7,035,596
	Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг	165	
81854	Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг /гадаад/	23	2,006,648
	Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг /Дотоод/	44	
<b>Дүн</b>			<b>57,728,674</b>
Зээлийн эргэн төлөлт			-6,213,220

БШУ-ны Сайдын шууд зарцуулсан төсвийн зориулалт

Код	Арга хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/
80415	Түшиц эмнэлэгт олгох татаас	2,883,866
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,233,340
81856	Монгол-Германы хамтарсан технологийн дээд сургуульд олгох татаас	2,286,625
<b>Дүн</b>		<b>6,403,831</b>

## 6.2 Дээд боловсролын үр дүнгийн зорилтот түвшний биелэлт

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд мэргэжлийн боловсролын дөрвөн (4) үзүүлэлт батлагдсан.<sup>63</sup>

Дээд боловсролын үр дүнгийн 2022 оны зорилтот түвшний ерөнхий биелэлт 108.3% гарлаа.

### Хүснэгт 6.2 Дээд боловсролын 2022 оны үр дүнгийн зорилтот түвшний биелэлт

Хэмжих үзүүлэлт	Хэмжих цаг хугацаа	2022 оны зорилтот түвшин	2022 оны гүйцэтгэл	Биелэлт, %
Их, дээд сургуулийн тоо	2022-2023 оны хичээлийн жил	88	69	<b>127.5%</b>
Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо	2022-2023 оны хичээлийн жил	500	508	<b>101.6%</b>
Тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо /багш/	2022-2023 оны хичээлийн жил	3727	5,824	<b>156.3%</b>
Тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо /сувилагч/				
Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан суралцагчийн тоо	2022-2023 оны хичээлийн жил	15000	7,168	<b>47.8%</b>

<sup>63</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1638159577231>

## 7. БОЛОВСРОЛ, ШУ-НЫ БОДЛОГО, УДИРДЛАГА

71808 Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага хөтөлбөр нь боловсролын үндсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь туслах, дэмжих үүрэгтэй ямар нэг боловсролын түвшинд хуваагдах боломжгүй, нийтлэг бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Энэ хөтөлбөр дээр бүртгэсэн байсан бусад хөтөлбөрт хамааралтай зарлагын хэсгийг тухайн хөтөлбөрт нь хуваарилсан болно.

Боловсролын үнэлгээний төвийн чиг үүргийг өргөжүүлж, дүрэм, зохион байгуулалтын бүтцийг БШУ-ны Сайдын тушаалаар<sup>64</sup> шинэчлэн баталлаа. Төв нь боловсролын бүх түвшний үнэлгээ, шалгалт зохион байгуулах, үнэлгээний удирдлага, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Боловсролын үнэлгээний төвийн чиг үүргийг оновчтой болгосноор боловсролын судалгааны хүрээ өргөжиж зөвхөн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн үнэлгээнд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байсан бол боловсролын бүх түвшний суралцагч, багш, байгууллагын үнэлгээний асуудлыг цогцоор нь авч үзэх шийдэл, арга хэмжээ хэрэгжүүлдэг болсон үр дүн гарч байна. Энэ хөтөлбөрт Боловсролын үнэлгээний төв, Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтэс, Зээлийн сангийн төсвийн зарлага, хэрэгжүүлж буй арга хэмжээг бүртгэдэг. Боловсрол, ШУ-ны бодлого удирдлагад 30.2 тэрбум төгрөг зарцуулав.

### Хүснэгт 7.1 Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага, 2022 оны төсвийн урсгал зарлага

Код	Арга хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/
80704	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	<b>1,173,600</b>
<b>Боловсролын байгууллагууд</b>		
1	Боловсролын үнэлгээний төв	5,456,952.1
2	Боловсрол, шинжлэх ухааны яам	5,395,097.2
3	Боловсролын ерөнхий газар	5,772,035.9
4	Аймаг, нийслэлийн Боловсролын газар, Дүүргийн Боловсролын хэлтэс	11,687,835.1
5	Зээлийн сан	788,963
	<b>Дүн</b>	<b>29,100,883.3</b>

<sup>64</sup> БШУ-ны Сайдын 2022 оны А/21 дүгээр тушаал

## 8. БОЛОВСРОЛ, ШУ-НЫ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

71809 Боловсрол, ШУ-ны судалгаа, шинжилгээ хөтөлбөр нь боловсролын үндсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь туслах, дэмжих үүрэгтэй ямар нэг боловсролын түвшинд хуваагдах боломжгүй, нийтлэг бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Боловсролын мэдээллийн технологийн төв болон боловсролын судалгаа хийдэг Боловсролын хүрээлэнгийн явуулж буй үйл ажиллагааг бүртгэнэ. Энэ хөтөлбөр дээр бүртгэсэн байсан бусад хөтөлбөрт хамааралтай зарлагын хэсгийг тухайн хөтөлбөрт нь хуваарилсан болно.

Боловсрол, ШУ-ны судалгаа, шинжилгээ хөтөлбөрт 11.6 тэрбум төгрөг зарцуулав. “Боловсролын хүрээлэн”-г “Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн” болгон өөрчлөн зохион байгуулж,<sup>65</sup> дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар<sup>66</sup> баталлаа. Хүрээлэн нь боловсролын хөгжлийн онол, арга зүйн судалгааны ажил эрхлэх, боловсролын шинэчлэл, өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлох, инноваци хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний үр дүнгийн мэдээллээр үйлчлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Харин Боловсролын мэдээллийн технологийн төв нь боловсролын салбарын цахим шилжилтийг эрчимжүүлж, боловсролын үйлчилгээг иргэн бүрд орон зай, цаг хугацаанаас үл хамааран хүргэх дэд бүтцийг хөгжүүлэхээр ажиллаж байна.<sup>67</sup>

### Хүснэгт 8.1 Боловсрол, ШУ-ны судалгаа, шинжилгээ, 2022 оны төсвийн урсгал зарлага

Боловсролын байгууллага		Байгууллагын үйл ажиллагааны 2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/	
Боловсролын хүрээлэн		1,952,614.3	
Боловсролын мэдээллийн технологийн төв		4,385,258.5	
<b>Дүн</b>		<b>6,337,872.8</b>	
Хуваарилаагүй үлдсэн арга хэмжээ болон түүний төсвийн зарлага			
Код	Арга хэмжээ	2022 оны урсгал төсвийн зарлага /мян.төг/	Бусад хөтөлбөрөөс шилжүүлсэн зарлага
80220	Холбооны суваг ашиглах	2,937,133.30	
80316	Цахим шилжилт арга хэмжээ	638,147.80	490,984.6
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,192,468.90	
<b>Дүн</b>		<b>5,258,734.60</b>	<b>490,984.6</b>

<sup>65</sup> Засгийн газрын 2021 оны 407 дугаар тогтоол

<sup>66</sup> БШУ-ны Сайдын 2022 оны А/10 дугаар тушаал

<sup>67</sup> Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 111 тогтоол



---

## ■ НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БШУ-ны</b>	Боловсрол, шинжлэх ухааны
<b>БУМС</b>	Боловсролын удирдлагын мэдээллийн систем-esis.edu.mn
<b>ДБ</b>	Дээд боловсрол
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ЕБ</b>	Ерөнхий боловсрол
<b>ЕШ</b>	Ерөнхий шалгалт
<b>СЯ</b>	Сангийн яам
<b>СӨБ</b>	Сургуулийн өмнөх боловсрол
<b>МБ</b>	Мэргэжлийн боловсрол
<b>МСҮТ</b>	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
<b>НТБ</b>	Насан туршийн боловсрол
<b>НҮТС</b>	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
<b>НҮБХХ</b>	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
<b>ҮСХ</b>	Үндэсний Статистикийн Хороо
<b>ТХЗ</b>	Тогтвортой хөгжлийн зорилго
<b>ТЭЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ЭЗХАХБ</b>	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
<b>ПК</b>	Полтехникийн коллеж
<b>ШҮ</b>	Шалгуур үзүүлэлт

---

## ■ НОМЗҮЙ

### Монгол хэл дээр

БШУЯ. 2023. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр: Боловсрол, шинжлэх ухааны яамны 2022 оны жилийн эцсийн тайлан. Улаанбаатар.

НҮБХХ. 2020. Боловсролын салбарын төсвийн зарлагын шинжилгээ. Улаанбаатар.

ҮСХ. 2018. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа.

### Англи хэл дээр

Department for Education. 2023. Consolidated annual report and accounts: For the year ended 31 March 2023. Annual Report presented to the House of Commons by Command of His Majesty, UK.

D. McBride. 2008. Public Institutions Scorecard: Searching for common and comparable elements to evaluate Public Organizations' Performance. Syracuse University Maxwell School of Citizenship and Public Affairs. <http://danielmcbride.info/wp-content/uploads/2013/03/Research-Public-Institution-Scorecard.pdf>

Harvard Kennedy School. 2000. The Oregon Benchmark Program: The Challenge of Restoring Political Support. <http://case.hks.harvard.edu/the-oregon-benchmarks-program-the-challenge-of-restoring-political-support/>

Metropolitan Group. 2009. Measuring What Matters, The Challenge of Quantifying Social Change. [http://www.metgroup.com/assets/690\\_measuringwhatmatterscree.pdf](http://www.metgroup.com/assets/690_measuringwhatmatterscree.pdf)

ILO. 2022. Youth not in employment, education or training in Asia and the Pacific 21 Trends and policy considerations.

National Performance Management Advisory Commission. 2010. A Performance Management Framework for State and Local Government: From Measurement and Reporting to Managing and Improving. <http://www.nasbo.org/sites/default/files/APerformanceManagementFramework.pdf>

OECD. 2022. Education at Glance. <https://www.oecd-ilibrary.org/docserver/3197152b-en.pdf?expires=1691750683&id=id&accname=guest&checksum=B3C939C036C178368D-6877B7E2EC6721>

University of North Carolina School of Government. 2016. North Carolina Benchmarking Project. <http://www.sog.unc.edu/resources/microsites/north-carolina-benchmarking-project>





9 789919 905941